

СЭЛЭНГЭ АЙМГИЙН УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

2024-12-02

Тус төв нь 2024 оны батлагдсан төсөв 3108452400 төгрөгийн төсөвтэйгээр үйл ажиллагаагаа явуулж, зайлшгүй хүрэлцэхгүй байгаа зардлыг төсвийн зарлагын ангилал хооронд шилжүүлэх замаар төсвийн ерөнхийлөн захирагчаас шийдвэр гаргуулан зарцуулж ажилласан.

Үйл ажиллагаандаа “Ус цаг уур орчны хяналт шинжилгээний тухай”, “Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай”, Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоол, хөтөлбөр, заавар журмыг мөрдлөг болгон Цаг уур орчны шинжилгээний газраас батлан гаргасан ус, цаг уур, байгаль орчны шинжилгээний хөтөлбөрт ажлын тасралтгүй байдал, технологийн мөрдөлтийг хангах, ажилчдын мэргэжил мэдлэг, ажлын хариуцлагыг дээшлүүлэх, Ус цаг уур, байгаль орчны мэдээ мэдээллийг хэрэглэгчид шуурхай хүргэх, мэдээ мэдээлэл, шинжилгээний ажлын чанарыг сайжруулахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа.

Тайлангийн хугацаанд Төсвийн төвлөрүүлэн захирагчтай хийсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 хэсэг, 16 зорилт, 37 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 37 ажил хийгдэж гүйцэтгэл 99.8% -тай байна.

Тус төвийн хамт олон 2024 онд ус цаг уур, байгаль орчны шинжилгээний хөтөлбөрт ажлыг бүрэн цаг хугацаанд нь технологийн дагуу хийж гүйцэтгэн шинжилгээ мэдээлэл үйлчилгээний ажлын хэвийн, тасралтгүй байдлыг хангаж ажиллалаа.

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

1.1. УЛСЫН СҮЛЖЭЭНИЙ УС, ЦАГ УУРЫН ӨРТӨӨ, ХАРУУЛЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРТ АЖИЛ.

1.1.1 Цаг уурын шинжилгээний ажил: Өртөө, харуулд хөтөлбөрийн дагуу хийгдэж байгаа цаг уурын анхан шатны ажиглалтын дэвтэр, хүснэгт, өөрөө бичигч лентүүдийг сар бүр Персона_Мис программад шивж оруулан шалгагдсан TAB хүснэгтийг дэвтэр, ленттэй нь тулган техник ба анхан шатны онол, орон зайн шүүмж шалгалт хийж аргачилсан дэлгэрэнгүй хариу зааварчилгыг бичиж нийт салбаруудад сар бүр ба нэгдсэн дүнгийн хамт албан бичгээр буюу утас, и-мэйл хаягаар нь цаг тухайд илгээж ажиллалаа.

УЦУОСМХ-ийн цаг уурын секторт сар бүрийн 10-ны дотор өмнөх сарын шалгалдсан ISX, TAB, RES-ыг сарын эмхэтгэл, шүүмж хамт хүргүүлэн ажиллаж байна. 2024 онд өртөө, харуулын цаг уурын шинжилгээний ажлын чанар үр дүн 99.13% өмнөх оноос -0.17%-ийн буурч ажилласан байна.

2024 онд өртөө, харуулын цаг уурын шинжилгээний ажлын нэгдсэн дүн

Жилийн дүн	Үзүүлэлт	Сүхбаатар	Баруунхараа	Орхон	Ерөө	Орхонтуул	Цагааннуур	Зүүнхараа	Баруунбүрэн	Зүүнбүрэн	Зэлтэр	Хүдэр	Бугант	Хушаат	Дундаж
	т/и	100	100	100	100	100	99.8	100	100	100	100	100	100	100	100
	х/б	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100
	а/ч	98.9	97.4	98.5	97.7	98.8	98.2	99.1	96.7	98.9	98.1	95.9	94.5	94.5	97.5
	м/б	99.2	98.6	98.3	98.5	98.5	98.4	99.3	96.5	99.5	98.0	99.4	96.2	96.2	98.2
	м/з	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100
Дундаж 2024		99.62	99.20	99.35	99.25	99.47	99.31	99.67	98.64	99.69	99.22	99.05	98.14	98.13	99.13
Дундаж 2023		99.81	99.24	99.24	99.34	99.36	99.34	99.36	99.16	99.22	99.22	99.22	99.16	99.33	99.31

2023 оны цаг уурын өртөө, харуулын шинжилгээний ажлын цаасан суурьтай баримтыг архив мэдээллийн дэд сангийн зохицуулагчид 3 улиралд багтаан хүлээлгэн өгсөн.

УЦУОСМХүрээлэнгийн УАӨНСХэлтэсээс манай салбаруудын шинжилгээний ажлын 2023 оны 12 дугаар сарын тайлан материалд хяналтын шалгалт хийгдсэн дүнгээр А/Ч-99.3%, Ш/Ч-98.7%, 2024 оны 3 дүгээр сарын тайлан материалд шалгалт хийсэн дүнгээр А/Ч-98.6%, Ш/Ч-99.7%, 7 дугаар сарын тайланд хяналтын шалгалт хийгдсэн дүн А/Ч-98.6%, Ш/Ч-98.8%, 09 дүгээр сарын тайланд хяналтын шалгалт хийсэн дүн А/Ч-99.4% Ш/Ч-99.6%-тай дүгнэгдсэн бөгөөд А/Ч-98.9% буюу өмнөх оноос 0.2%-иар буурсан, Ш/Ч-99.2% буюу өмнөх онтой тэнцүү үзүүлэлтэй дүгнэгдэж ирсэн.

САЛБАРЫН АЖЛЫГ САЙЖРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

Ажил сайжруулах төлөвлөгөөг боловсруулан батлуулж түүний дагуу дараах ажил үүргийг хийж гүйцэтгэсэн. Хамгийн их алдаа гаргадаг нүдэн баримжааны ажиглалт үүл үзэгдлийн уялдаа, аюултай үзэгдэл, хөрсний гадаргын байдлыг голлон авч үзэж тогтмол шалгаж тухай бүр зөвлөмж бичиж сар бүр хариу заавар бичиж хүргүүлэн ажиллаа.

2024-01-05-ны өдрийн хамт олны хурлаар хэлэлцсэн өртөө, харуул ажлын байранд тогтвор сууршилтай байх, ажиглалтыг хугацаанд хийх зэрэг шийдвэрийн үндсэн дээр өртөө, харуулын тус тус группт чатанд харьцангуй чийгшил явуулах шаардлага тавьсан. Уг шаардлагийг Орхон, Зүүнхараа, Баруунхараа, Орхонтуул, Цагааннуур, Ерөө өртөө, Бугант, Зэлтэр харуулууд мэдээлэл өгсөн. Мөн тухайн сарын 31-ний 14 цагт хээрийн цасны хэмжилт хийсэн зурган файл шаардсанаас Сүхбаатар, Баруунхараа, Зүүнбүрэн, Хушаат, Орхонтуул, Цагааннуур, Бугант мэдээллийг явуулсан. Хээрийн цасны хэмжилт хийх бүртээ зурган файл явуулж байх шаардлага тавьсан дээрх өртөө, харуулууд тогтмол зурган файлыг явуулж гүйцэтгэл 95%-ийн биелэлттэй байна.



Шалган туслах ажлаар Баруунхараа, Зүүнхараа, Цагааннуур, Орхон өртөө, Зүүнбүрэн, Зэлтэр, Хүдэр харуулд нийт 7 өртөө, 3 харуулд ажиллаж станцын байр, багаж төхөөрөмж, ашиглагдаж байгаа багажийн бүрэн бүтэн байдал, дэвтэр хүснэгтийг шалгахад гарсан алдаа дутагдлыг газар дээр нь арилгуулан, боломжгүй зөрчлийг хугацаа заан арилгуулж алдаа дутагдлуудын талаар зааварчилгаа өгч тестээр шалгалт авч ажилласан байна. Нийт 35 хүнээс дундаж дүн 60-95% дүгнэгдсэн.

№	Өртөө, харуулын нэр	Шалгалт хийсэн тоо	Шалгалт хийсэн сар, өдөр	Биелэлт %	Шалгалтаар илэрсэн алдаа, Үл тохирлыг арилгасан байдал
1	Цагааннуур өртөө	1	V/27	100	Алдаагүй
2	Баруунхараа өртөө	2	VII/25	100	Алдаа дутагдалгүй
			X/06	100	Алдаа дутагдалгүй.
3	Зүүнхараа өртөө	2	VII/25	100	Алдаа дутагдалгүй
			XI/06	98	Талбайн өвс өндөр, талбайн нүцгэн хөрс сайн сийрүүлээгүй, өртөөний өрөө тасалгаа цэвэрлэгээ үйлчилгээ сайн хийгээгүй.
4	Зэлтэр	1	V/28	98	Тунадас хэмжигч хагарсан
5	Хүдэр	1	IV/30	100	Алдаа дутагдалгүй
		1	XI/06	100	Алдаа дутагдалгүй
6	Зүүнбүрэн	1	X/12	100	Алдаа дутагдалгүй
		1	VII/11	100	Алдаа дутагдалгүй

1.1.2. ХАА-н цаг уурын шинжилгээний ажил

2024 онд ХААЦУ-ын салбар нь 7 өртөө, 6 харуулд батлагдсан хөтөлбөрийн дагуу дараах ажилуудыг хийсэн. 2023 оны 17 сумын 45 зогсоол цэгт хийсэн бэлчээрийн төлөв байдлын ажиглалтын ХД-8 дэвтэр, Dima мэдээллийн санд XII/22- II/08-ны өдөрүүдэд 45 ширхэг дэвтэрт техник, шүүмж шалгалт хийж, 11 дэвтэр шивж, 34 дэвтэр шивэлттэй тулгаж, 15 санг нийлүүлэн, 45 ширхэг дэвтэрийн 18000 цэгийн бичиглэл тулган, шалгаж, 90ш фото зурагуудыг нэгтгэсэн

Тухайлбал II/06-07ны өдөр 45 зогсоол цэгийн 1,2 шугамын 90ш фото зурагуудад нэр өгч цэгцлэх, дэвтэр, самбар дээрх бичиглэлтэй тулгах ажилуудыг хийж, II/07нд 45ш ХД-8 дэвтэрт, мэдээллийн сан, шүүмж шалгалт нэгтгэн төвд явуулсан

Өвлийн бэлчээрийн цасны явуул судалгааны ажиглалтыг 1-р сарын 24нд Алтанбулаг сумын Бүргэдэй, Суварга, Хяраан, Зцэг, 1-р сарын 25нд Шаамар сумын Дулаанхаан, Охинды, Дэлгэрхаан нийт 3 цэгт цасны хээрийн хэмжилт хийсэн. Хэмжилтээр цасны дундаж зузаан, дундаж нягт, хунгар, хөрийн зузааныг тодорхойлж зудын үнэлгээ, тайлан бичиж, дээрх сумдын тамгын газар хүргүүлж ажилласан.

17 сумын 45 зогсоол хийсэн өвлийн цасны хэмжилтийн ХХ-26 хүснэгтэнд шалгах, шивэх ажлыг 2-р сарын 19-нд хийж хугацаанд нь ХААЦУСХэлтэст дамжуулсан. Мөн баг тус бүрээр зудын үнэлгээ хийж, Сэлэнгэ аймгийн мал өвөлжилтын цаг агаарын нөхцлийн тойм бичиж сайтанд байршуулав.



17 сумын 45 зогсоол хийсэн өвлийн цасны хэмжилтийн ХХ-26 хүснэгтэнд шалгах, шивэх ажлыг 2-р сарын 19-нд хийж хугацаанд нь ХААЦУСХэлтэст дамжуулсан. Мөн баг тус бүрээр зудын үнэлгээ хийж, Сэлэнгэ аймгийн мал өвөлжилтын цаг агаарын нөхцлийн тойм бичиж сайтанд байршуулав.

Бэлчээрийн ургамлын үе шат, ургамлын өндөр, гэмтлийн ажиглалтыг хашаалсан талбайн 7 өртөөнд 504 удаа, хашаалаагүй талбайн 6 харуулд 126 удаа, хөрсний чийгийн ажиглалтыг 6 өртөөнд 105 удаа, бэлчээрийн хортон шавьжийн ажиглалт 273 удаа, мэрэгчийн ажиглалт 39 удаа таримал ургамлын үзэгдэл зүйн ажиглалтын 6 станцад 594 удаа тус тус хэмжилт хийсэн. ХААЦУ-ын ажиглалтын материалд 4-10 сарын ХД-1,1а 91ш, ХД-5 63ш, ХД-76 91ш, ХД-2 42 ширхэг дэвтэрт, бэлчээрийн ургамлын 360 ширхэг, таримал ургамлын үе шатны 81 ширхэг хатаамалд техник болоод шүүмж шалгалт хийсэн. 2024 оны ХД-8 45 ширхэг дэвтэрт шүүмж шалгалт хийж, шивэлтийн ажилууд хийгдэж байна.

Арав хоногийн агро дундаж мэдээ 36 удаа шалгаж, алдаагүй дамжуулахад хяналт тавьж ажиллаа.

Тариалангийн талбайн хаврын хөрс гэсэх хугацаа, хаврын угтвар нөөц чийгний урьдчилсан мэдээ зохиосон.

Тариалангийн талбайн хаврын хөрс гэсэх хугацаа, хаврын угтвар нөөц чийгний урьдчилсан мэдээ зохиосон. Хөрсний автомат Баруунхараа, Цагааннуур өртөөний багажуудыг III/1, IV/1 нд тус тус байрлуулж, сар бүрийн **10, 20, 30/31**-ний өдрүүдэд мэдээг татан авч, агро дундаж мэдээнд 26 удаа коодлон дамжуулсалж, эх мэдээнд шүүмж шалгалт хийн, архивлан хадгалж байна.

4,10-дугаар сард уринш, гуурстай талбайн хөрсний чийгийн явуул судалгааг 12 сумын уринш, гуурстай 48 талбайд тодорхойлж, дүн мэдээг нэгтгэн гарган ХААЦУСХэлтэст хүргүүлсэн.

Бэлчээрийн төлөв байдлын судалгааг 17 сумын 45 багийн 18000 цэг дээр хийж 225 ургацын мэдээг нэгтгэн 2023-2024 оны бэлчээрийн даац багтаамжийн дүн мэдээг гаргасан

Таримал ургамлын явуул судалгааны 10 сумын 33 зогсоол цэгт 8 үзүүлэлтээр сумдын ХАА-н тасгийн дарга нартай хамтран хийж, ажиглалтын мэдээг ХХ-2 хүснэгтэнд нэгтгэн, шүүмж шалгалт хийж, мэдээг 9/15-нд ХААЦУС хэлтэст цахим байдлаар дамжуулсан

5-р сарын 25нд Ерөө өртөөний хашаалсан талбайд ZENTRA ZL-6 хөрсний автомат багажыг байрлуулан туршилтын ажилыг эхэлүүлсэн



■ 2023 оны 10-р сард БОАЖСайдыг ирэхэд хашаалсан талбайн хашаа яаралтай хэрэгтэй байгаа талаар хүсэлт гарган сайдын багцаас 20 сая төгрөг шийдүүлж, 5 өртөөний хашаалсан талбайг шинэ төмөр хашаатай болгов.



Анхан шатны салбар нэгжийн ажиглалтын чанарыг сайжруулан ажиллах зорилтын хүрээнд:

ХААЦУ-ын технологийн шинэчлэл нь орон нутагт бүх төрлийн ажиглалтыг шилжүүлж, агродундаж мэдээгээр ирсэн коодоор улсын сүлжээний ажиглалтын мэдээний бүтэц, чанар, мэдээ дамжуулалт болон шүүмж шалгалтын ажлыг дүгнэх журамд өөрчлөлт оруулсан. Иймээс өртөө, харуулын ажиглагчдын мэдлэг чадварыг ахиулах, сургах, чадавхжуулах ажлыг үе шаттайгаар хийж байна

Баруунхараа 10 удаа, Цагааннуур 9 удаа, Орхонтуул 9 удаа, Сүхбаатар 8 удаа, Ерөө 6 удаа, Орхон 10 удаа, Зүүнхараа өртөөнд 10 удаа, Зүүнбүрэн, Баруунбүрэн, Түшиг, Бугант, Хушаат, Хүдэр сумдад 8 удаа facebook chat, VideoCall-аар тус тус холбогдон 10

хоног бүрийн ажиглалтын дэвтэр, коод, ургамлын үе шатны хамаатал авсан байдлыг 9,19,25, 10,20,30/31/ нд байнга шалгаж, гарч буй алдааг багасгах талаар арга зүйгээр ханган ажиллаа.

ШАЛГАН ТУСЛАХ АЖИЛ:

Гэнэтийн болон төлөвлөгөөт шалгалтыг 7 өртөө, 6 харуулд нийтдээ давхардсан тоогоор 13 салбарт 110 удаа, сар бүрийн 10 хоногт хийлээ. Шалгалтаар ихэнх өртөө, харуулд сар бүрийн 9,19,25, 10,20, 30,31 нд Сүхбаатар, Баруунхараа, Орхон, Ерөө, Орхонтуул, Цагааннуур, Зүүнхараа, Баруунбүрэн, Зүүнбүрэн, Түшиг, Хүдэр, Бугант, Хушаат өртөө, харуулд цахимаар шалгалт хийхэд дэвтэр хөтлөлт дутуу, агны цухуйлт, бундуйжилтийн хатаамал буруу авсан, Бугант, Хүдэр, 3-н арав хоногийн тойм дутуу бичсэн, Хушаат Бэлчээрийн болон хортон мэрэгчдийн дэвтэр буруу хөтөлсөн, V/28нд Орхон суманд очиж шалгахад дэвтэр хөтлөлт дутуу, VI/20 Сүхбаатар ажиглалтыг технологийн дагуу хийгээгүй зэрэг зөрчил илэрсэн бөгөөд шалган туслах ажлын биелэлт 99.9% -тай дүгнэгдэж өмнөх оноос 1.5 хувиар ахисан байна

Сургалтын ажил:

Боловсон хүчний мэдлэг чадварыг дээшлүүлэн, сургалт семинарт хамрагдуулсан талаар: Бүх өртөө, харуулд арав хоног бүр хашаалсан, хашаалаагүй талбай, таримал ургамлын үзэгдэл зүйн ажиглалт, хөрсний чийгийн ажиглалтыг технологийн дагуу хийх, ХД-1, ХД-5, ХД-2, ХД-7б дэвтэрүүдийг зааварын дагуу хөтөлж бичих, Ак-02 коодонд гарч буй алдааг засах, дамжуулах талаар нийт цагийн зааварчилгаа арга зүйгээр ханган ажилсан байна. ХААЦУ-ын салбаруудын бүх төрлийн ажиглалтаар хичээл заах, хичээлийн хөтөлбөр гарган нийт 26 цагийн хичээл заагдсан байна. Үүнд:

№	Өртөөний нэр	Хичээл заасан цаг
1	Сүхбаатар	8ц
2	Орхон	8ц
3	Ерөө	4ц
4	Орхонтуул	6ц
5	Цагааннуур	6ц
6	Зүүнхараа	8ц
7	Баруунхараа	7ц
	Нийт	47ц

ТЕХНОЛОГИЙН ШИНЭЧЛЭЛ-ШУУРХАЙ МЭДЭЭГЭЭР МЭДЭЭЛЛИЙН САНГ БАЯЖУУЛАХ НЬ сэдэвт / Google Meet/- ээр холбогдон нийт 18 цагийн семнар, сургалт хийсэн.

2024 оны ХААЦУ-ын шинжилгээний ажлын нэгдсэн дүн 99,99% буюу өмнөх жилээс 0,4 %-иар өссөн байна.

Сар	Үзүүлэлт	Сүхбаатар	Баруунхараа	Орхон	Ерөө	Орхонтуул	Цагааннуур	Зүүнхараа	Баруунбүрэн	Зүүнбүрэн	Зэлтэр	Хүдэр	Бугант	Хушаат	Дундаж
Жи	М/ и	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100
	х/ б	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100

лийн жил	а.м/чанар	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100
	а.м/бүтэц	99,2	99,2	99,7	99,2	99,7	99,2	100	99,6	100	100	99,6	99,7	96,9	99,96
2024		99,8	99,8	99,9	99,8	99,9	99,8	100	99,9	100	100	99,9	99,9	99,2	99,99
2023		99,7	99,2	99,7	99,5	99,9	99,9	99,9	99,5	99,6	99,6	99,5	99,5	99,5	99,6

2024 онд ХААЦУ-ын шинжилгээний ажлын дүнгээр Зүүнхараа, Зэлтэр, Зүүнбүрэн өртөө, харуул тэргүүлэн ажиллаж өмнөх жилээс 0.1-0.4 хувиар өсч, Цагааннуур өртөө, Хушаат харуул агро дундаж мэдээ алдаатай дамжуулсанаас 0.1-0.3 хувиар өмнөх жилээс дүн буурсан байна.

1.1.3. Ус судлалын шинжилгээний ажил.

Ус судлалын горимын ажиглалт хэмжилт судалгааг шинжилгээний ажлын хөтөлбөрт багтаан технологийн мөрдөлт, заавар журмын дагуу хийж мэдээ мэдээллийг дотоодын болон олон улсын солилцоонд гаргах, ус судлалын мэдээллийн санг нөхөн бүрдүүлэхээр ажил үүргээ хийж гүйцэтгэлээ УЦУОСМХүрээлэнгийн ГУСХэлтэсээс ирсэн бичиг мэйлд тухай бүр нь хариуг сүлжээгээр өгч ажиллалаа.

Салбарын ахлах техникч, харуулын ажиглагчийн 2023 оны ажлыг дүгнэж, 2024 онд хийх ажлын төлөвлөгөөг гарган батлуулж, хүрэх түвшинг тодорхойлж дүнгийн гэрээ байгуулан ажиллав.

Сар бүрийн 5-ны өдрийн шинжилгээний хуралд салбарын сарын ажлын явц дүн мэдээг хурлаар хэлэлцэн холбогдох санал алдаа оноогоо хэлэлцэн ажиллаж ирсэн.

УЦУОСМХүрээлэнгийн Ус судлалын сектороос ирсэн хариутай бичиг хугацаатай тайлан мэдээг цаг хугацаанд нь ftr сүлжээгээр дажуулан ажилладаг.

Шинжилгээний ажлын талаар:

Харуулын ажиглагч нарын ажлыг улирал, жилээр дүгнэж байр эзлүүлэн сайн ажилласан ажиглагчид нарыг төвөөс урамшуулж ирсэн. Энэ оны хувьд харуулууд жигд сайн ажиллаж жилийн дундаж дүнгээр Сэлэнгэ-Зүүнбүрэн харуулын ажиглагч Алтанцэнгэл орсон.

2024 он жилийн эцэс	Сэлэнгэ - Сүхбаатар	Сэлэнгэ - Зүүнбүрэн	Орхон - Сүхбаатар	Орхон - Орхон	Ерөө - Ерөө	Ерөө - Дулаанхаан	Хараа - Баруунхараа	Хүдэр - Хүдэр	Зэлтэр - Зэлтэр	Ерөө-Бугант	
Тайлангийн ирц	100	100	100	100	100	100	100	100	100	100	100
Материал боловсруулалт	98,13	99,83	97,63	96,33	96,81	97,48	99,38	96,50	98,58	98,20	97,88
Ажиглалтын чанар	99,25	99,83	98,85	97,85	97,13	99,48	99,25	99,25	99,75	99,50	99,01
Хөтөлбөрийн биелэлт	100	100	100	90	95	100	100	100	100	100	98,5
Хамаарлын хувь		100	92	100	92	92	100	100	100		97
Мэдээ дамжуулалт	100	100	97,93	99,2	100	100	100	99,58	97,63	100	99,43
Муруйн хамаарал		99,7	97,8	98	96	99,4	96	98,6	99,9		98,18
Багаж ашиглалт	100	100	100	100	100	100	100	100	100	100	100
Хөдөлмөр хамгаалал	100	100	100	100	100	100	100	100	100	100	100
Дүн	99,63	99,93	98,24	97,93	97,44	98,71	99,40	99,33	99,54	99,67	98,98
Эзлэх байр	3	1	8	9	10	7	6	5	4	2	

Шинжилгээний ажлын явц:

- Уурхайн худгийн хэмжилтийг Сэлэнгэ-Зүүнбүрэн харуулд 5-р сарын 1-нээс сар бүрийн 5,10,15,20,25,30-ний өдрүүдэд
- Булгийн ундаргын ажиглалтыг Хүдэр-Хүдэр харуулд 7-р сарын 25-наас сар бүр 3,6,9,12,15,18,21,24,27,30-ний өдрүүдэд
- Худгийн хэмжилтийг Хараа-Баруунхараа харуулд 6-р сарын 1-нээс сар бүрийн Уурхайн худгийн хэмжилтийг Сэлэнгэ-Зүүнбүрэн харуулд 5-р сарын 1-нээс сар бүрийн 5,10,15,20,25,30-ний өдрүүдэд хэмжилтийг хийсэн.

Эргийн эвдрэл: 2018 оноос эхлэн хэмжилтийг GPS-ээр хэмждэг болсон бөгөөд ГУСХэлтсээс өгөгдсөн түвшинд хамруулан Орхон-Сүхбаатар харуул дээр гулдрил хэмждэг бөгөөд ерөнхий ажиглалтын хэсгийн шаардлага хангасан байдал нь сонгосон ажиглалтын хэсэгт Усны аж ахуйн усан хангамжийн худгаас доош 2км-т, ус судлалын харуулын түвшний чиглэлээс дээш 3 км зайтай, уг чиг нь төгс бус тохойрол, хажуугийн хошуу туудасны хэв шинжийг хамарсан.



Хэмжилтийг 7-р сарын 8, 9-р сарын 20-нд хийсэн.



Хэмжилтийн үр дүнг агстар IX.20-аар харуулав /усны түвшин Н-281 см/

- **Биологийн дээж:** Сэлэнгэ-Сүхбаатар, Орхон-Сүхбаатар, Хараа-Баруунхараа, Ерөө-Ерөө харуулуудаас 5-9-р саруудад голын ёроолын амьтад авч төрөл зүйл, тоо ширхэгээр нь ангилан төвд нийт 20 ш дээж хүргүүлсэн ба голуудаас хамгийн их илэрдэг нь өдөрч хаварч бол тогтмол илэрдэг нь хоовгон, хирономид ялаа байна.

Харуулын нэр	Төрөл зүйл	Тоо ширхэг	Тайлбар
Сэлэнгэ-Сүхбаатар	6	420	Өдөрч, хаварч, хоовгон, бясаа, дун, хясаа
Орхон – Сүхбаатар	6	419	Өдөрч, хаварч, хоовгон, бясаа, дун, хясаа
Ерөө-Ерөө	3	414	Өдөрч, хаварч, тор нэхэгч хоовгон, Соно
Хараа - Баруунхараа	5	414	Өдөрч, хаварч, тор нэхэгч хоовгон, бясаа, дун, Хромет ялаа /авгалдай/

- Урсац бодолт болон мэдээллийн сан үүсгэх: 2023 оны урсац бодолтыг ГУСХэлтэсээс заасан хугацаанд хүргүүлсэн. Датабэйс болон Реки-Режим программын шивэлтийг цаг хугацаанд нь шивж дамжуулсан.

Шүүмж шалгалт: Голын усны горимын мэдээг хэмжиж, ажиглаж тодорхойлсон физик утга нь хэр үнэн зөв болохыг тогтоохын тулд шүүмж шалгалт хийгддэг. Шүүмж шалгалтаар хийгддэг ажлууд:

- Хөтөлбөрийн биелэлт бүрэн эсэх
- Зэрэгцээ тоололт хийсэн тоо
- Зэрэгцээ тоололтоор шонгийн хөдөлгөөн илрүүлсэн талаархи тэмдэглэл
- Сарын туршид их, бага, дундаж түвшинг хамруулан өнгөрөлт хэмжсэн эсэх
- Материал боловсруулалт
- Усны түвшний шалтгаангүй үсрэлт
- Багаж төхөөрөмжийн ажиллагааны талаар тайлбар
- Дэвтэр хөтлөлт
- Муруйн уялдаа
- Дээд доод харуулын усны түвшний уялдаа
- Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөж гарын үсэг зурсан үгүйг шалгаж, хариу заавар, зөвлөгөө өгч ажилладаг.

Шалган туслах ажлын талаар:

Сэлэнгэ-Сүхбаатар -1, Орхон – Сүхбаатар –2 удаа, Хараа – Баруунхараа –2 удаа, Ерөө – Ерөө -1, Ерөө-Бугант – 1, Хүдэр – Хүдэр -1, удаа тус тус ШТА хийгдсэн. Шалган туслах ажлын явцад тенологийн зөрчил гараагүй, үүрэг даалгаврын биелэлт 100%

Багаж арчилгаа ашиглалт болон хангамжийн талаар:

- Шалган туслах ажлаар явж байхдаа багажуудыг шалгаж, заавар өгч, засах шаардлагатай багажыг төвд байгаа сэлбэг хэрэгсэлээр сэлбэж, хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан.
- Орхон-Орхон, Ерөө-Ерөө, Хүдэр-Хүдэр ус судлалын харуулуудын Вертушкыг Багаж хэмжилзүйн лаборторт шалгалтанд өгч засварлуулсан. Харуулын ажиглагчид өөрсдийн боломжид тулгуурлан хэмжилтээ хэвийн хийж байна.
- Ус судлалын сектороос хувиарласан 20ш биологийн дээжний сав, 108ш УД-1 дэвтэр, 400ш УД-2 дэвтэр харуулуудад тараан ажилласан.

Хөдөлмөр хамгаалалын талаар:

- Шалган туслах ажлын үеэр ажиглалт хэмжилт хийхэд ХХАА-ны дэвтэр дээр гарын үсэг зуруулж нь мөрдлөг болгон ажиллуулав.
- Харуулын ажиглагчид байгаль цаг уурын аюултай үзэгдэлтэй үед хэмжилт хийх, голын мөсөн дээр ажиллах, өнгөрөлт хэмжих үеүдэд ХХААЗаавартай танилцан гарын үсгээ зурж ажилласан.
- ХХААЗааврын дэвтэрээр хэвлэж, файлаар тараан ажилласан.
- Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах үүднээс өнгөрөлтийн харуул нь төвөөс зайдуу орших Орхон, Зүүнбүрэн, Орхон-Шаамар, Орхон-Орхон харуулуудад өнгөрөлт хэмжилтэнд зарцуулагдах шатахууны мөнгийг, сар бүр хангаж ажиллав.
- Гүүрэн дээр хэмжилт хийхэд хөдөлгөөнд оролцож байгаа машинууд ойрхон зөрөх, хурдаа хасахгүй байх гэх мэт эрсдэл үүсдэг учир ослын гурвалжин тэмдэгтээр анхааруулах тэмдэгт хийн ажиллаж байна.
- Ус судлалын харуулууд өвөл мөсөн дээр ажиллах хөдөлмөрийн нөхцөлтэй байдаг учир дулаан нормын хувцасаар хангаж ажилласан.
- Усны аврах хантаазны нормын хугацаа нь дууссан харуулуудыг аврах хантаазаар хангаж ажилласан.

УД-1 дэвтэр –120ш, УД-2 дэвтэр – 304 ш, дэвтрийг хүлээн авч техник болон шүүмж шалгалт хийж, УХШ-1 хүснэгт, УХ-2а хүснэгт, гольдралын зураглал, хэмжсэн өнгөрөлтийн муруй зэргийг сар бүр УЦУОСМХ-н ус судлалын секторт хүргүүлж байна. Мөн нэгдсэн зураглалыг 2-н харуулын 6 элементээр 2 хувь, өнгөрөлтийн муруйг 2 харуулаар 1 хувь, олон жилийн дундаж муруйг харуулууд тус бүрээр сар бүр зурж ирлээ.

1.1.4. Орчны хяналт шинжилгээний ажил.

2024 оны жилийн байдлаар Сүхбаатар харуулаас хөтөлбөрийн дагуу ажлын өдөр бүрийн 08, 14, 20 цагуудад агаараас нийт 655 удаа сорьц авч хүхэрлэг хий болон азотын давхар ислийн шинжилгээг 253 удаа хийж, <http://192.168.100.13/currentweather/EDTS/login.asp> программд шивж оруулсан. Шинжилгээний дүнгээр Сүхбаатар сумын агаар дахь хүхэрлэг хийн дундаж 0.005 мг/м^3 , хамгийн их 0.013 мг/м^3 , азотын давхар ислийн дундаж 0.019 мг/м^3 , хамгийн их 0.038 мг/м^3 байна. Эдгээр бохирдуулагч хийнүүд нь MNS 4585:2016 стандарт дахь хүлцэх агууламж/ цаашид ХА гэх/-аас давсан тохиолдол ажиглагдаагүй.

Сүхбаатар сумын агаар дахь нарийн ширхэглэгт тоосонцор болон том ширхэглэгтийг 2024 оны байдлаар 366 удаа хийсэн. Нарийн ширхэглэгт тоосонцор буюу PM2.5-ын дундаж агууламж I-VI, IX саруудад 0.002-0.043 мг/м³-ээр буурсан бол VII, VIII, X, XI саруудад 0.001-0.008 мг/м³-ээр өссөн байна. байлаа. Том ширхэглэгт тоосонцорын дундаж агууламж өмнөх оноос I-VI, IX саруудад 0.002-0.065 мг/м³-ээр буурсан бол VII, VIII, X, XI саруудад 0.002-0.011 мг/м³-ээр өссөн байна.

Цацраг идэвхжилийн түвшний ажиглалтыг өдөр бүр 08, 14 цагт хөтөлбөрийн дагуу хийдэг ба идэвхжилийн түвшний жилийн дундаж агууламж агаар болон хөрсөнд 0.10 микро зерверт/цаг хэмжээтэй байна. Хамгийн их агууламж 0.13 микро зерверт/цаг хүрсэн байна. Монгол орны цацраг идэвх жилийн жилийн дундаж фон түвшин 0.20 микро зерверт/цаг байдаг бөгөөд түвшнээс даваагүй байна.


Сэлэнгэ аймгийн Мандал сумын агаарын чанарын харуул агаарт хүхэрлэг хий болон азотын давхар ислийг тодорхойлдог бөгөөд 2021 оны 10 дугаар сарын 27-ноос эхлэн тоосны хэмжилтийг хийх автомат багажтай болсон. Мандал сумын агаараас нийт 592 удаа дээж авч, 225 удаагийн химийн шинжилгээг стандарт аргачлалын дагуу чанартай хийж гүйцэтгэсэн.




2024 оны 11 сарын байдлаар Мандал сумын агаар дахь хүхэрлэг хийн дундаж агууламж 0.006 мг/м³, хамгийн их агууламж 0.042 мг/м³, хамгийн бага агууламж 0.001 мг/м³ байна.




Өмнөх онтой харьцуулахад I-V, IX-XI саруудад 0.002-0.033 мг/м³-ээр буурсан бөгөөд VI, VII, VIII саруудад 0.001-0.003 мг/м³-ээр өссөн байна.



Эхний 11 сарын байдлаар Мандал агаарын чанарын хоёрдугаар харуулын ажиглалтын дүнг харахад өмнөх оноос том ширхэглэгт тоосонцорын хэмжээ сарын дунджаар 6.89 мкг/м³-ээр буурсан байна.




Эхний 11 сарын байдлаар Мандал агаарын чанарын хоёрдугаар харуулын ажиглалтын дүнг харахад өмнөх оноос нарийн ширхэглэгт тоосонцорын хэмжээ сарын дунджаар 6.4 мкг/м³-ээр буурсан байна.



Мандал сумын том болон нарийн ширхэглэгт тоосонцорын хувьд халаалтын улиралд стандарт дахь хүлцэх агууламжаас 3.14-7.9 дахин их гардаг.

2024 оны хуримлагдсан цасны шинжилгээг 2 дугаар сарын 07-нд Сүхбаатар сумын 19 цэгээс авч хийлээ.



Хуримтлагдсан цасны шинжилгээгээр хамгийн их агуулагдаж байгаа цэгээр шүдэнзний арын айлын орчимд авсан сорьцонд сульфат 115.42 мг/л, 25-р тогочын айллуудын дундаас авсан дээжинд нитратын агууламж 0.64 мг/л, жаран айллуудын дундаас авсан дээжинд хлорын агууламж 5.67 мг/л, аммонийн агууламж 3.05 мг/л агуулагдаж байлаа. Хуримтлагдсан цасны усан орчин нь шүдэнзний арын айлын орчимд авсан сорьцонд 7.96 байсан бөгөөд бусад цэгт 6.33-6.98 сул хүчиллэг чанартай байна.

2024 онд сарын нийлбэр тунадсыг 05-10 сар хүртэл Сүхбаатар станцаас авч дараахи элементүүдээр химийн шинжилгээг хийсэн.

Сар	NH ₄ , мг/л	NO ₃ , мг/л	Cl, мг/л	SO ₄ , мг/л	PH	EC, мкс/см	Орсон тунадас, мм
05	0.21	0.23	2.8	24.3	6.79	93.5	570.0
06	0.64	0.21	2.1	7.0	6.62	65.6	1390.0
07	0.40	0.14	2.8	5.2	6.88	99.2	186.0
08	0.37	0.38	4.3	10.9	6.95	101.3	672.0
09	0.22	0.41	2.8	9.9	6.69	86.5	336.0
10	0.34	0.21	2.8	30.6	6.85	297.0	238.0

Сарын нийлбэр тунадасны шинжилгээний дүнгээс үзэхэд 570-1390 мм тунадас орж, усан орчин 6.62-6.95 сул хүчиллэг чанартай ба нитратын их агуулга 6 сард, сульфатын их агуулга 10 сард хүрсэн байна.


2024 оны 01 сараас 11 сар хүртэл “Сэлэнгэ цэнгэг ус” ОНӨААТҮГ-ын цэвэрлэх байгууламжийн хаягдал усанд 11 удаа шинжилгээ хийлээ.



Шинжилгээний дүнгээс үзэхэд “Сэлэнгэ цэнгэг ус” ОНӨААТҮГ-ийн цэвэрлэх байгууламжийн хаягдал усны цэвэршилт эхний 11 сарын байдлаар дундаж нь 71.04 хувьтай байлаа.



Цэвэрлэх байгууламжын хаягдал усны химийн хэрэгцээт хүчилтөрөгчийн агууламж дөрөв, зургаа, есөн сараас бусад сард MNS 4943:2015 стандарт дахь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 1.33-3.55 дахин давсан байна.



Цэвэрлэх байгууламжын хаягдал усны нийт азотын агууламж найман сараас бусад бүх саруудад MNS 4943:2015 стандарт дахь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 1.05-3.43 дахин давсан байна.

1.1.5 Цаг уурын өртөө, харуулын шуурхай мэдээг дамжуулах, сүлжээ ашиглалтын хэвийн ажиллагаа

Цаг уурын 7 өртөө, 6 харуулын шуурхай мэдээг олон улсын болон бүсийн солилцоонд гаргах ажил 99,99 хувьтай байна.

Шуурхай мэдээ: 7 өртөөний погод мэдээ 18704, харуулын мэдээ 6012 удаа, нийт 24,716 мэдээ дамжихаас 22 мэдээ хугацаанаас хоцорч, 100 мэдээ алдаатай дамжсан байна. Өртөө, харуулын шуурхай мэдээ дамжилтын дүн 99.99% буюу өмнөх оны мөн үеэс 0.41 хувиар өссөн дүнтэй байна.

2024 оны сумдын шуурхай мэдээ дамжуулалтын дүн:

	Өртөө, харуул	Хугацаа хоцорсон мэдээ/хоц	Алдаатай дамжуулсан мэдээ/ кор	Мэдээ дамжилт	Байр
1	Сүхбаатар	99.3	99.4	99.333	V
2	Баруунхараа	98.7	99.3	99.000	VI
3	Орхон	99.4	99.3	99.375	IV
4	Ерөө	99.5	99.3	99.417	III
5	Орхонтуул	99.5	99.6	99.542	II
6	Цагааннуур	99.6	99.8	99.667	I
7	Зүүнхараа	99.3	99.6	99.417	III
8	Баруунбүрэн	99.3	99.8	99.542	IV
9	Зүүнбүрэн	99.9	99.8	99.833	III
10	Зэлтэр	99.9	99.8	99.854	II
11	Хүдэр	99.9	99.8	99.833	III
12	Бугант	99.8	99.9	99.875	I
13	Хушаат	99.6	99.2	99.375	V

Салбаруудаас мэдээ дамжуулалтын хувьд сайн ажилласан нь **Цагааннуур, Орхонтуул, Бугант, Зэлтэр** өртөө, харуулууд байлаа. Хамгийн их мэдээ хоцролт, КОР/алдаатай мэдээ дамжуулсан нь **Баруунхараа, Сүхбаатар, Орхон өртөө, Хушаат, Баруунбүрэн** харуулууд орж байна. Гарч буй нийтлэг алдаа нь үзэгдлийн нэмэлт бүлэг, шивэлтийн алдаа хийх, шөнийн цагаар унтах зэрэг ажиглагч өөрөөс нь шалтгаалсан алдаа дутагдал гарч байна. Энэ талаар өөрт нь болон станцын даргад сар, улирал бүр танилцуулж, зөвлөж ажиллаж байна.

ТЕХНИК ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН БЭЛЭН БАЙДАЛ:

- Төв дээр тогны хязгаарлалт хийгдсэн, гэнэтийн тасалдал үүссэн тохиолдолд Урьдчилсан мэдээлэх салбарын 2 ш компьютерийг “МХСүлжээ ТӨК”-ын нөөц генераторт холбон мэдээлэл үйлчилгээний ажлаа тасалдалгүй хэвийн явуулж байна.
- Мөн синоптик инженерийн компьютерийг Нислэгийн цаг уурын төвийн Аюулгүй байдал, чанарын менежерийн 10/2024 дугаартай дүгнэлтэд тусгасан шаардлага, зөвлөмжийн дагуу Филиппин улсад үйлдвэрлэсэн Schneider Electric компаны ВХ1100LI-MS загварын тог баригч (UPS)-тэй болгосон. Уг төхөөрөмж нь 73 минут ажиллах хүчин чадалтай.

2022 он	2023	2024	2024/сайдын багцаас/
Суурин компьютер-6 Зөөврийн компьютер-1	Суурин компьютер-7 /зөвлөгөөний үеэр авсан/ Зөөврийн компьютер-3	Зөөврийн компьютер-1, 27 инч дэлгэц-1, Гега свитч-1, Принтер-2, Самсунг гар утас-4, Гагнуурын алх, кабель таслагч, сүлжээний багаж, камерын багц Тендерээр: Зөөврийн компьютер-5 Ухаалаг дэлгэц-1, 3 үйлдэлт өнгөт принтер, хар принтер	Зөөврийн компьютер-6 Суурин компьютер-14 ширхэг

- Мөн тендерээр 86 инчийн ухаалаг дэлгэц-1 ширхэг, i7 зөөврийн компьютер-2 ширхэг, i5-зөөврийн компьютер-3 ширхэг, 3 үйлдэлт хар принтер-2 ширхгийг тус тус худалдан аавалт хийж үйл ажиллагаандаа ашиглаж байна.
- Төвийн болон станц харуулуудын компьютерийн хэрэглээний болон бусад програм хангамжинд үүссэн доголдлыг цаг тухайд нь засаж, хөдөө орон нутгийн техникч нарт Anydesk, болон teamviewer програм ашиглан зааж, шаардлагатай програм хангамжийг суулгаж ажиллаа.
- Компьютерийг вируснээс хамгаалах програм болох Kaspersky Internet Security-ын сунгалтын лицензийг тухай бүрт нь сунган ажиллаж байна.
- Цаг уурын нөхцөл байдлыг хянах зорилготой Milesight 360 камерын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллаж байна.
- Мэдээлэл холбоо сүлжээ ТӨК дээр байрлах Media converter буюу эхлэлийн төхөөрөмж эвдэрсэн тул 2024 оны 10 дугаар сард шинэчилж сольсон.

Төвийн конторын өргөтгөлийн байранд байрлах свитч тогны хэлбэлзлээс шалтгаалж шатсаныг сольж, хэвийн ажиллаж байна.

1.1.6 Климат мэдээний ирц, чанарын талаар:

7 станцын 10 хоногийн болон сарын климат мэдээг 336 удаа шалгаж, дамжуулалтанд нь хяналт тавьж ирсэнээс чанар 100%-тай буюу өмнөх оноос 0,1%-иар өссөн байна.

1.1.7 Аюул, агаар мэдээний ирц, чанарын талаар:

Цаг уурын станц, харуулуудаас зохиож ирүүлсэн байгаль ус цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн 182 аюул агаар мэдээнд хяналт тавьж шалгасан байна. Аюул агаар мэдээний ерөнхий дүн нь 99.9 % буюу өмнөх оны дүнтэй харьцуулхад чанар нь 0,2 хувиар буурсан. ирц нь өөрчлөлтгүй байна. Ирц нь 100% буюу өмнөх оны дүнтэй харьцуулахад өөрчлөлтгүй дүнтэй байна. Үүнд:

- Орон шуурга 106 удаа
- Нойтон цас 124 удаа
- Мөндөр 3 удаа
- Хүчтэй салхи 48 удаа
- Нөөлөг салхи 1 удаа

1.1.8 Багаж, хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын талаар:

УЦУОШТ-ийн салбар, өртөө, харуулуудад ажиллаж буй инженер, техникч, ажиглагч нарын шинжилгээний ажилд ашиглаж, хэмжил үйлдэж буй хэмжих хэрэгслийн хэвийн ажиллагаа, түүний хэмжлийн нэгдмэл байдлыг тогтвортой хангахын тулд хэмжих хэрэгсэлд хийгдэх, үзлэг, үйлчилгээ, тохируулгын ажлыг тогтоосон хугацаанд хийж буй эсэхэд хяналт тавьж, шаардлагатай багаж төхөөрөмжөөр хангах, түүний ашиглалт, хадгалалт, хамгаалалтанд гарч буй зөрчил, дутагдлыг арилгуулах, багаж тоног төхөөрөмжийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах ажлыг тогтмол зохион байгуулан ажилласнаар автомат цаг уурын станцын ажиллагаа доголдолгүй 5 минут тутмын мэдээ тасралтгүй бүрэн дамжсан байна.

Хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, /шалгалт тохируулгын/-ын ажлын 2024 оны график төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна.

Графикийн дагуу:

- Агаарын даралтын болон чийг температурын зөөврийн шалгалтын багажийг БОХЗТЛ-д баталгаажуулалт хийлгэсэн.
- Цаг уурын 7 өртөөдийн автомат станцыг шалгалтын багажаар харьцуулж баталгаажуулалт хийлээ.
- Цаг уурын харуулд ашиглаж буй HUAYN автомат багажуудыг харьцуулсан тоололт хийж, зөрүүтэй мэдрүүрийг сольж тавилаа.

13 салбарын цахилгаан жин, цасны жинг шалгаж баталгаажуулан шинжилгээний ажилд ашиглаж байна.

Цацрагийн түвшин хэмжих багаж, РН хэмжигч, Кондуктометр, Спектофотометрт баталгаажуулалт хийлгэн шинжилгээний ажилд ашиглаж байна.

УЦУОШТ-ийн салбар, өртөө, харуулуудад ажиллаж буй инженер, техникч, ажиглагч нарын шинжилгээний ажилд ашиглаж, хэмжил үйлдэж буй хэмжих хэрэгслийн хэвийн ажиллагаа, түүний хэмжлийн нэгдмэл байдлыг тогтвортой хангахын тулд хэмжих хэрэгсэлд хийгдэх, үзлэг, үйлчилгээ, тохируулгын ажлыг тогтоосон хугацаанд хийж буй эсэхэд хяналт тавьж, шаардлагатай багаж төхөөрөмжөөр хангах, түүний ашиглалт, хадгалалт, хамгаалалтанд гарч буй зөрчил, дутагдлыг арилгуулах, багаж тоног төхөөрөмжийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах ажлыг тогтмол зохион байгуулан гүйцэтгэж ирлээ.

Ажиглалтын технологийн мөрдөлтийг сайжруулах, ажиглалт хэмжилтэнд гарч байгаа алдаа, багаж төхөөрөмжийн ажиллагааны үл тохирлыг арилгахын тулд шалган туслах ажлын графикийн дагуу ээлжит, гэнэтийн болон цаг үеийн шалгалтыг нийт 11 салбарт 11 удаа хийж ажиглалт хэмжилтийн технологийн мөрдөлт, багаж хэмжих хэрэгслийн ажиллагаа, байрлалыг шалгаж, арчилгаа үйлчилгээг тогтмолжуулан сайжруулах талаар өртөө, харуулын ажиглагч, техникч нарт тодорхой аргачилсан зөвлөмж, үүрэг даалгавар өгөн биелэлтэнд нь хяналт тавин ажиллаж байна.

Үзлэг шалгалтад хамрагдсан багаж, төхөөрөмж

№	Үзлэг үйлчилгээ хийгдсэн багажийн нэр	Үзлэг хийсэн багажийн тоо
1	Термометр	63
2	Аягат барометр	6
3	Гигрометр	14
4	Термограф	7
5	Гигрограф	7
7	Цасны жин	10
9	Цахилгаан жин	14
10	Флюгер	20
11	Хурын хувин	13
12	Хэмжүүрийн аяга	13
13	Цан мөстөл илрүүлэх төхөөрөмж	10
11	Вертушка	8
12	Хатаах шүүгээ	6
	Дүн	175

Цаг уурын өртөөдөд сар бүрийн 5, 15, 25-нд хийж байгаа автомат станцын мэдрүүр, механик багажуудын харьцуулсан зэрэгцээ тоололтын материалд цаг уурын боловсруулалтын салбарын инженер техникч нар тогтмол хяналт тавин ажиллаж байна. Шалгалт хийж буй өртөө, харуулын ажиглалтын талбайд байрлуулсан жин үдийн тэмдэгтийг нарны дундаж цагаар тооцон шалгасны дээр уг тэмдэгтэй флюгаркийн болон автомат станцын салхины зүгийн чиглүүлэгчийг харьцуулан шалган үзэхэд хойд зүгийн чиглүүлэгч нь жин үдийн тэмдэгттэй давхцаж байсан.

Шалган туслах ажлын явцад 8 салбарын автомат цаг уурын станцын даралт, агаарын температур, чийгийн мэдрүүрийг шалгалтын багажуудтай зэрэгцээ тоололт хийж шалгахад тоололтын зөрөө агаарын чийг 0,1-2,0%, температур 0,0-0,4 градус, даралт 0,1-0,3 гПа буюу багажийн ажиллагаа хэвийн технологийн шаардлага хангаж байна. Цаг уурын өртөө харуулд аянга цахилгааны үзэгдэлтэй үед аюулгүйн ажиллагааны журмын дагуу тус станц дээр богино хугацаанд авах арга хэмжээ авах талаар зөвлөмж бичгээр хүргүүлэн ажилласан.

1.1.9 Тоног төхөөрөмж хэмжих хэрэгслийн засвар, үзлэг үйлчилгээний талаар:

Сүхбаатар, Мандал агаарын чанарын харуулын агаарын дээж авах зориулалтын аспиратор, мини рамп –н хэмжилтийн хурдыг шалгалтын багажтай харьцуулсан тоололт хийж шалган хурдыг тохируулсан, ажиллагаа хэвийн байна

ЦУАС-ын хэвийн тасралтгүй ажиллагааг хангахын тулд өртөөдийн газардуулга, аянга зайлуулагчийг шинэчлэн төхөөрөмжлөх ажлыг дэс дараатайгаар авч хэрэгүүлж байна. ЦУАС-дын газардуулгыг хэмжиж үзэхэд Орхон, Орхонтуул. Зүүнхараа, Сүхбаатар , Баруунхараа 4,0-ом, Ерөө, Цагааннуур 4,0-ом дээш үзүүлэлттэй байна.

Автомат станцын компьютерт үүсэх гэнэтийн эрсдлийг тооцон шивэлтийн компьютеруудад нь AWS-ын програмыг суулгаж, мэдээний тасралтгүй бэлэн байдлыг хангасан.

ЦУАС, Компьютерийн хэрэглээний болон бусад программ хангамжид үүссэн доголдлыг цаг тухайд нь засаж, Anydesk, TEAMVIEWER программ ашиглан хөдөө орон нутгийн техникч нарт шаардлагатай программ хангамжийг суулган зааварчилга өгч ажилладаг.

Компьютер, тоног төхөөрөмжийг вируснээс хамгаалах Kaspersky програмыг автомат станцтай компьютеруудад суулган вируснээс хамгаалж байна.

ЦУ-ын автомат станц, мэдээ мэдээллийг тасралтгүй шуурхай дамжуулах үүднээс ЦУОШГ-аас хувиарлаж өгсөн шинэ 6 компьютерийг Сүхбаатар, Баруунхараа, Орхон, Ерөө, Цагааннуур, Хушаат салбаруудад хувиарласан. Мөн зарим сумдын УАБ-ын шивэлтийн компьютерийг үзүүлэлт сайтай хуучин компьютерээр солих зэрэг ажлыг хийсэн.

Компьютерийн засвар үйлчилгээг тухай бүрт нь хийж ажиллалаа /Зайнаас автомат станцын програм суулгах-Зудaa, персoнa мисс програм суулгах 5 удаа, бусад тохиргоо үйлчилгээг цаг тухайд нь хийж өгч, зөвлөж ажилласан. Компьютерийн үйлдлийн систем шинэчлэн суулгах, хэрэглээний болон мэргэжлийн програмуудыг суулгах ажлыг 10 удаа хийсэн.

Төвийн болон сумдын интернет сүлжээний асуудал, доголдолыг тухай бүрт нь шийдэж хэвийн болгож ажилласан.

Мэдээ дамжуулалт-99,5

Сүлжээ ашиглалт-100

Тоног төхөөрөмжийн бэлэн байдал-100

Цаг уурын харуулуудыг автоматжуулах ажлын хүрээнд Хүдэр, Хушаат, Зэлтэр, Баруунбүрэн сумдын автомат багажд цаг тухайд нь үзлэг шалгалт хийж, харьцуулсан тоололт хийлээ.Зөрүүтэй мэдрүүрийг сольж тавилаа.Мөн тус сумдын автомат багажуудыг путикнээс гаргаж тусад нь хайрцаглаж ажиглалт хэмжилт хийх үед гарч байсан алдаа дутагдалыг арилгалаа.

Шинжилгээний ажлын тасралтгүй байдлыг ханган 16 салбарт 39 ширхэг багаж төхөөрөмжийг хүргүүлэн ажиллалаа.

№	Салбарууд	Багаж төхөөрөмж
1	Бугант	Батист
2	Ерөө	Батист
3	Зүүнбүрэн	Батист
4	Хүдэр	Батист
5	Орхонтуул	Батист
6	Орхон	Батист
7	Баруунбүрэн	Батист
8	Зэлтэр	Батист

9	Хушаат, Хүдэр, Баруунбүрэн, Ерөө	Менкурк
10	ус	Урсгалын хурд хэмжүүр
11	ус	Секундометр
12	Хур шим	Хөрсний чийгийн мэдрүүр
13	Ерөө, Баруунхараа	ZL хөрсний, чийг температурын логгер
14	Зүүнхараа	AWS-ын баттерей
15	Орхон	AWS-ын баттерей
16	Цаг уурын 6 харуулд	Dell15-12 процесср 6
17	Орхонтуул	Хяналтын камер
18	ЦУОШТөвд	Хяналтын камер
19	Ус судлал	Нивлер
20	Цагааннуур	Хөрсний чийгийн автомат багаж
21	Орхон	Хөрсний өрөм
22	Холбоо сүлжээ	Сүлжээ салаалагч
23	Холбоо сүлжээ	12v тэжээлийн блок
24	Бугант	Хөрсний мэдрүүр
25	БОШЛ	I5 notebook компьютер
26	7 станц, 6 харуул	Радон детектор
27	ЦАЗН экспедиц	Цаг уурын хэмжлэт хийх автомат багаж 3 ширхэг
28	Орхон	Агаарын чийг, температурын мэдрүүр
29	Цагааннуур	Maws201 автомат станц
30	Сүхбаатар	AWS-Ын12V аккумулятор
31	Ерөө	AWS310b автомат станц
32	Бугант	Салхины даачик
33	Орхон	Тог баригч
34	Орхон	Тог тогтворжуулагч
	Бүгд	39

Өртөө харуулуудын тасралтгүй ажиллагааг хангах, багаж төхөөрөмжийг технологийн зөрчилгүй бүрэн ажиллуулахад анхааран засвар үйлчилгээг тогтмол хийж байна. Багаж төхөөрөмжид гарсан эвдрэл, гэмтэл, үл тохирлыг илрүүлэн шуурхай арга хэмжээ авч ажиллалаа. Үүнд:

Өртөө харуулуудын тасралтгүй ажиллагааг хангах, багаж төхөөрөмжийг технологийн зөрчилгүй бүрэн ажиллуулахад анхааран засвар үйлчилгээг тогтмол хийж байна. Багаж төхөөрөмжид гарсан эвдрэл, гэмтэл, үл тохирлыг илрүүлэн шуурхай арга хэмжээ авч ажиллалаа. Үүнд:

- Зүүнхараа станцын тоололт тасалдах үзэгдэл гарч байгаа тул үзлэг шинжилгээ хийхэд Rs-485 холболт гэмтсэн тул шинээр холболт хийв
- Цагааннуур цаг уурын станц тогны хязгаарлалтаас болж гэнэтийн тог тасралтаар тэжээлийн блок шатсан тул шинээр сэлбэж ажилд орууллаа.
- Орхон станцын мэдээ програмд тоололт очихгүй байсан тул үзлэг үйлчилгээ хийж хэвийн ажилд оруулав.
- Сүхбаатар станцын газраар явсан холболт элэгдэж муудаж мэдээ тасалдах үзэгдэл гарч байсан тул шинээр холболтын монтаж хийж гүйцэтгэв.
- Баруунхараа, Зүүнхараа станцын логгерт мэдээ дамжуулах модемыг суулгаж ажилд оруулав.
- Баруунхараа станцад зохион байгуулсан Цаг уур, уур амьсгалын өртөө, харуулын чадавхийг сайжруулах сургалтанд “Автомат станцын хэмжилт хийх, технологийн дагуу арчилгаа үйлчилгээ хийх, гарсан гэмтэлийг олох, засварлах” ажлын талаар сургалт хийв.
- Зэлтэр цаг уурын харуулын автомат багаж чийг, температур зөрүүтэй гарж байсан тул шалгалт тохируулга хийлээ.


- Баруунхараа, Сүхбаатар, Орхонтуул, Цагааннуур, Зүүнхараа, Бугант, Ерөө станцуудад мэссэж модемыг суурьлуулж хяналт тавин ажиллаж байна.
- Цаг уурын автомат станц болон бусад тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг ханган өртөөдөд аянга зайлуулагчийг суурилуулах ажил хийгдэж байна.Өртөөдийн газардуулгыг тухай бүр хэмжиж хэвийн байгаа эсэх шалгаж ажиллаж байна.
- CAMS620-ыг орон нутгийн санхүүжилтаар Орхон. Зүүнхараа станцуудын логгерыг хайрцаглаж шинээр монтаж хийлээ.




- Орхон цаг уурын станц аянга цахилгааны улмаас логгер шатсан тул засвар үйлчилгээ хийж хэвийн ажилд оруулав.Тус станцад шинээр тог баригч, тогтворжуулагч тавилаа.
- Цаг агаарт зориудаар нөлөөлөх ажилд ашиглагдаж байгаа 713-Xd хөдөлгөөнт радарт үзлэг үйлчилгээ хийж илэрсэн гэмтлийг сэргээн засварлаж 2024 оны ЦАЗН ажилд ажилууллаа..
- Ерөө цаг уурын станцад БОХЗТЛ-ын мэргэжилтэн Д.Довчин, Б.Цэрэндорж нар ирж шинээр AWS310b маркын автомат станц суурьлуулав.



-Бугант цаг уурын салхины зүгийн даачиг гэмтсэн тул түүнийг солих, засварлах ажил хийгдлээ.Мөн тус матчын нугас хугарсан тул гагнуур хийж засварлав.



Автомат станцтай газаруудад цаг уурын мэдээг минут дамжуулах модем Сүхбаатар, Ерөө, Бугант, Баруунхараа, Зүүнхараа, Орхонтуул, Цагааннуур сумдад тавьж хэвийн ажиллаж байна. Уг модемын суурьлуулсанаар тус станцын Статистик дүн дунджаар, цаг уурын элементийн түүвэр, бодит хугацааны өгөгдөл зэргийг <http://119.40.97.105:8080/> сервирт дамжуулж байна.



1.1.10 Төрийн архивын үйл ажиллагааны талаар:

2024 АМДС-д хүлээн авах цаасан суурьтай баримтыг хөмрөг үүсгэх хувиарийн дагуу УЦУОШАлбаны Уур амьсгал боловсруулалтын салбараас 49 хн 12621, ХАА салбараас 37 хн 2272, Ус судлалын салбараас 21 хн 3679, Байгаль орчны шинжилгээний лаборатори 9 хн 1340 хуудас шинжилгээний материалыг тус тус хүлээн авч цэгцлэн санд оруулсан. Нийт 116 хадгаламж нэгж, 19912 хуудас мэдээ шинээр оруулсан 2024 Өөрөө бичигч багажийн лентний бүртгэлийг хийж термограф 7хн 2555, гигрограф 7 хн, 2555, барограф 6 хн 312 нийт 5422 ширхэг лент боловсруулагдсан болохыг тогтоон нэгдсэн дүн мэдээг дамжуулсан. Архив мэдээллийн дэд санд ашиглагдаж байсан Panasonic KV-7065 скайнар нь 2015 оноос хэвийн үйл ажиллагаа нь доголдож хэд хэдэн удаа булыг нь сольж ашиглах гэсэн боловч шаардлага хангахгүй байсан учир байгууллагийн бичиг хэргийн ажилтны HP Scanjet Pro 2000 s2 түргэн скайнараар 2016-2023 оны 7 өртөөний өөрөө бичигчийн лентийг нийт 22

хадгаламжийн нэгжийн тоо 43854 хуудасны тоо скайнарадаж зурган файл болгон цахим сан үүсгэж хүлээлгэн өгсөн.

2024 онд төсөвийн тодотголоор EPSON DS-30000 скайнараар Баруунхараа, Сүхбаатар, Ерөө, Орхон өртөөдийн 1985-1987 оны цаг уурын ажиглалтын ЦД-1 дэвтрийг нийт 12 хадгаламжийн нэгжийн тоо, 5394 хуудасны тоо сканердаж зурган файл болгон цахим сан үүсгэн, данс хөтлөн мөн цаасан баримтыг 11 сард АМСХ-д хүргүүлсэн.

Архивын дүн- 99.34 % буюу өмнөх оны дүнтэй харьцуулхад 0.46%-иар буурсан байна.

1.1.11 Мэдээллийн дэд сангийн үйл ажиллагааны талаар:

Цаг уурын 7 өртөөний 2023 оны 12 дугаар сараас, 2024 оны 1-10 дугаар сарын автомат станцын горимын 3298 файл, 338,42 GB хэмжээ бүхий мэдээг хүлээн авч шалган сар бүрийн 10-ны дотор сүлжээнд тавьсан. Мэдээллийн дэд сангийн дүн 100% буюу өмнөх оны дүнтэй харьцуулхад өөрчлөлтгүй байна.

1.2 Уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох ган, цөлжилтийн эрсдэлийг бууруулах, таримал болон бэлчээрийн ургамлын ургацыг нэмэгдүүлэх, ой хээрийн түймрийг унтраахад дэмжлэг үзүүлэхэд агаар мандлын үзэгдэл, процесст зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх, агаар, ус, хөрсний чанарт хяналт шинжилгээ хийх үйл ажиллагаа

1.2.1 Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны талаар:

2024 онд Цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедицүүдийн үйл ажиллагааг Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын А/123 тоот тушаалын дагуу эхлүүлж экспедицийн аюулгүй ажиллагааны заавар танилцуулж, гарын үсэг зуруулан харвалт хийсэн үеийн акт, код мэдээг тухай бүрт нь шуурхай дамжуулж байв.

Пуужингийн нөөцийг 2023 оны 10 сард 40 ширхэг пуужин, 2024 оны 4 сард нэмж 20 ширхэг пуужин авч нийт 60 ширхэг борооны пуужинтай үйл ажиллагааг эхлүүлсэн бөгөөд 5,6-р саруудад хэрэглээд 4 пуужингийн үлдэгдэлтэй болоод дахин 7-р сарын 23-нд нэмж 30 ширхэг пуужин авч ажилласан. Одоогийн үлдэгдэл 16ш пуужин байна.

ЦУОШТөвийн даргын А/17 тоот тушаалаар Сэлэнгэ Бороо -1,2,3, экспедицүүдийн бие бүрэлдэхүүнийг шинэчлэн томилж 5 дугаар сарын 21 -ний өдрөөс эхлэн 5дугаар сарын 21, 22, 23, 27, 28–ны өдрүүдэд, 6 дугаар сарын 5, 11, 18, 19, 20 –ны өдрүүдэд, 7 дугаар сарын 5, 20, 21, 25, 26 -нд, 8 дугаар сарын 01-нд Сэлэнгэ аймгийн нутагт үүлэнд зориудаар нөлөөлөн хур тунадас нэмэгдүүлэх, хөрсний чийгийг сайжруулах, ургамлын ургалтыг тэтгэх, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор цаг агаарын нөхцөл бүрдсэн нийт 10 удаагийн гаралтаар 15 процесст 30 удаагийн хээрийн ажиллагаа явуулж 74 ширхэг борооны пуужин харваж цаг агаарт зориудаар нөлөөлж болох бүх нөхцөлийг алдалгүй гарч ажилласан болно.

Пуужин хадгалах байранд тогтмол цэвэрлэгээ хийж, агаарын чийг, температурыг шалгаж тэмдэглэл хөтлөн ажиллаа. Мөн экспедиц ажиллах үед агуулхаас гаргасан

пуужинг ЦАЗН ерөнхий инженерт хариуцуулж пуужин гаргасан, хүлээлгэн өгсөн бүртгэл хийж байв.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

ЦАГ АГААРТ ЗОРИУДААР НӨЛӨӨЛӨХ БОРОО-1, 2, 3,4 ЭКСПЕДИЦ

ЗЭВСГИЙН АГУУЛХААС ПУУЖИН ГАРГАСАН, ЭРГЭЖ ТУШААСАН БҮРТГЭЛ

Сүхбаатар хот

2024 он

Зэвсгийн агуулахаас пуужин гаргасан бүртгэл

№...1 БорОО...1..

Экспедицийн нэр

Пуужин гаргаж авсан он сар өдөр	2024-05-01
Нэр, албан тушаал	Гарын үсэг
Зэвсгийн агуулах онгойлгох зөвшөөрөл өгсөн	С. ГАНБАТ
Авсан пуужингийн тоо	10
Пуужин хүлээн авсан	Х. Баярмаа
Пуужин хүлээлгэн өгсөн	С. Халсан

Зэвсгийн агуулахад пуужин эргүүлж тушаасан бүртгэл

№...01 БорОО...1..

Экспедицийн нэр

Пуужин эргүүлж тушаасан он сар өдөр	2024-05-01
Нэр, албан тушаал	Гарын үсэг
Зэвсгийн агуулах онгойлгох зөвшөөрөл өгсөн	О. Халсан
Тушаасан пуужингийн тоо	Ширхэг
Хөөрөөгүй пуужингийн тоо	Ширхэг
Пуужин хүлээлгэн өгсөн	Х. Баярмаа
Пуужин хүлээн авсан	С. Халсан

Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг орон нутгаас дэмжин хамтран ажилладаг бөгөөд аймгийн ЗДТГазартай гэрээ байгуулан 30 сая төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаандаа зарцуулан тухай бүрт тайлан мэдээг хүргүүлэн ажилласан.

Үйл ажиллагаа эхлэхийн өмнө 4 экспедицийн харвах төхөөрөмж, удирдлагын пульт, радарын станц, машин техникт засвар үйлчилгээ хийн сэлбэг хэрэгсэл авч ажилд бэлэн болгосон.

ЦУОШГазар Иргэний нисэхийн Ерөнхий газартай байгуулсан гэрээг мөрдөн үйл ажиллагаа явуулах бүрдээ зөвшөөрөл авч харвалт хийж байв.

Хур тунадас нэмэгдүүлэх хээрийн ажлын үеийн мэдээ, мэдээллийн ажлын хэвийн найдвартай шуурхай байдлыг хангах зорилгоор интернетийн хурдыг нэмэгдүүлж, экспедицийн дарга нарын гар утсыг нэгжээр ханган, урьдчилан мэдээлэх салбарын утсыг хот хооронд ярих байнгын эрхтэй болгон ажлын хэрэгцээнд ашиглаж байна. Мөн хээрийн хэмжилтэнд ашиглаж байгаа багаж төхөөрөмжийг шалган тохируулж ажлын бэлэн байдлыг хангуулж ажиллав.

2024 онд Цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедицүүдийн үйл ажиллагааг Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын А/123 тоот тушаалын дагуу эхлүүлж экспедицийн аюулгүй ажиллагааны заавар танилцуулж, гарын үсэг зуруулан харвалт хийсэн үеийн акт, код мэдээг тухай бүрт нь шуурхай дамжуулж байв.

Пуужингийн нөөцийг 2023 оны 10 сард 40 ширхэг пуужин, 2024 оны 4 сард нэмж 20 ширхэг пуужин авч нийт 60 ширхэг борооны пуужинтай үйл ажиллагааг эхлүүлсэн бөгөөд 5,6-р саруудад хэрэглээд 4 пуужингийн үлдэгдэлтэй болоод дахин 7-р сарын 23-нд нэмж 30 ширхэг пуужин авч ажилласан. Одоогийн үлдэгдэл 16ш пуужин байна.

Ерөнхийдөө 6, 7 дугаар саруудад маш их халалттай агаарын сарын дундаж температур олон жилийн дунджаас 0,5-2,3 градус дулаан, үнэмлэхүй их температур агаарт 30,0-34,8 градус, хөрсний гадаргад 52-68 градус хүрч халсан бөгөөд агаарт нийтдээ 6-23 өдөр 30 градусаас давж халсан нь хур тунадас багасах гол нөхцөл болсон.

Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг явуулахдаа Сэлэнгэ аймгийн засаг дарга, Онцгой байдлын газар, ХХААГазрын дарга мэргэжилтэнгүүдтэй нягт холбоотой байж Мандал, Баянгол, Зүүнбүрэн, Хушаат, Цагааннуур, Түшиг, Баруунбүрэн, Орхон сумдын засаг дарга нийт 8 сумын 15 аж ахуйн нэгжүүдтэй хамтарч ажиллалаа.

ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

2.1 УС ЦАГ УУР, ОРЧНЫ НИЙТИЙН МЭДЭЭГЭЭР ХЭРЭГЛЭГЧДЭД ШУУРХАЙ, ЧАНАРТАЙ ҮЙЛЧЛЭХ

2.1.1 Цаг уурын бүх төрлийн мэдээллийг хүлээн авах, цуглуулах, дотоодын болон олон улсын солилцоонд гаргах ажилд ашиглагдаж байгаа компьютер, сүлжээний техник, тоног төхөөрөмжийн тасралтгүй, шуурхай байдлыг хангаж ажиллах талаар:

Ус цаг уур орчны хяналт шинжилгээний мэдээ мэдээллийн тасралтгүй үйл ажиллагааг хангах, холбоо сүлжээний урсгалаар дамжиж буй мэдээ мэдээллийг түргэн шуурхай алдаагүй дамжуулах зорилгоор зохион байгуулалтын дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

- Сэлэнгэ аймгийн УЦУОШТ-ийн 7 станц, 6 харуулын интернэт холболтын хэвийн үйл ажиллагааг хангах, хяналт тавих ажлыг цаг тухайд нь хийж гүйцэтгэж ажилласан.
- Мэдээлэл солилцооны ажилд ашиглаж байгаа компьютер, свитч, модем, рүүтэрийн ажиллагааны байнгын хэвийн байдалд хяналт тавьж ажиллахгүй болсон тохиолдолд засах, хэвийн болгох арга хэмжээг цаг тухайд нь авч хэрэгжүүлж ажилласан.
- Компьютерийг вируснээс хамгаалах програм болох Kaspersky Internet Security-г төв болон салбар нэгжүүдийн компьютеруудад суулган, лицензийн сунгалтыг хийж цахим орчин дахь аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.
- Мэдээгээ алдаатай ирүүлсэн газруудад цаашид алдаа гаргахгүй ажиллахыг сануулж зөвлөмж анхааруулгыг өгч ажиллалаа. Өртөөний дарга нарт улирал бүр дүнг танилцуулж ажиллав.
- Мэдээллийн хөтөлбөрт ажлын биелэлтийг хангах, түүнийг хэрэгжүүлэх мэдээ, мэдээллийг цуглуулахад аймгийн Мэдээлэл холбоо сүлжээ ТӨК болон TOPNET компанитай хамтран ажиллаж, сүлжээ тасалдах, засвар үйлчилгээ хийгдэх үед албан хаагчдад мэдэгдэн ажиллаж байна.
- 2023 онд шинээр суурилуулсан Skywort-ын 8 ширхэг IP камерын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна.

2.1.2 Цаг агаарын төрөл бүрийн урьдчилсан мэдээ, тойм зөвлөмжөөр төрийн байгууллага, аж ахуйн нэгжид үйлчлэх

Сэлэнгэ аймгийн цаг агаарын урьдчилсан мэдээ болон тойм зөвлөмжийг аймаг, сум орон нутгийн удирдлага, ард иргэдэд, малчид, тариаланчдад түргэн шуурхай хүргэж үйлчлэх ажил хэвийн хийгдэж байна.

- Цаг агаарын аюултай болон гамшигт үзэглээс урьдчилан сэргийлэх мэдээ, анхааруулга мэдээ, урьдчилсан мэдээг ард иргэдэд, малчдад, тариаланчдад сүлжээ харгалзахгүйгээр MASS мессежээр шуурхай хүргэх

- Цаг агаарын мэдээ мэдээллийг “Гэрлэн самбарт” тогтмол гарган ажиллуулж байна.

- Зүүнхараа хотоор 1-5 хоногийн урьдчилсан мэдээг өдөр бүр зохиож УМС-т өгч Монголын үндэсний олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлдэг.

- Байгууллагын пейж хуудсуудаар өдөр бүр мэдээллээ түгээн ажиллаж байна.

Ард иргэд tsag-agaar.gov.mn- веб сайтын дэд сайт болох аймгуудын веб сайтаас мэдээллээ тогтмол авч хэвшсэн байсан бөгөөд уг сайтны ажиллагаа эвдрэлтэй доголдолтой байгаагаас одоогоор пейжээс мэдээллээ авч ажиллаж байна. Мөн бусад сувгуудыг бүрэн ашиглаж, үйлчилгээний ажлаа сайжруулахыг хичээж байна.

Мессеж мэдээгээр үйлчилсэн байдал:

Цаг агаарын бүх төрлийн урьдчилсан мэдээг 12-144 цагийн урьдчилгаатайгаар Сэлэнгэ аймгийн засаг дарга, засаг даргын орлогч, ЗДТГДарга, ИХДарга, ХХААЖДҮГДарга, ОБГ-ын дарга, Байгаль орчны газар, Авто тээврийн газар, Сэлэнгэ-энерго эрчим хүчний газар, АЗЗА газар, Цагдаагийн газар, Статистикийн газар болон бүх сумдын засаг дарга, орлогч, иргэд, тариаланчид, малчид бүхий 151 хэрэглэгчдийн гар утсанд сүлжээ харгалзахгүйгээр 5857 удаа мессежээр цаг агаарын урьдчилсан мэдээг шуурхай хүргэсэн байна.

Нийтийн хэрэгцээний урьдчилсан мэдээгээр үйлчилсэн байдал: Улирал, сар, 7, 1-5 хоног, 12 цагийн урьдчилалтай гаргадаг цаг агаарын бүх төрлийн урьдчилсан мэдээ, бодит болон тойм мэдээ, сэрэмжлүүлэх мэдээ, анхааруулга мэдээг төр засгийн удирдах дээд байгууллагуудад сар, улирлын мэдээг товхимол хэлбэрээр, радио, интернет, телевизээр өдөр тутмын мэдээг беллютень, факс, гэрэлт самбар, интернетээр мессеж болон файлаар <http://selenge.tsag-agaar.gov.mn/> сайтанд өдөр бүр байршуулан ажиллаж байна.

2024 оны жилийн эцсийн байдлаар сумдын мэдээгээр үйлчилсэн байдал / Үйлчилгээний тогтмолжилт, %/ Хагас хоног, 1-5 хоногийн мэдээгээр өдөр бүр, 7 хоногийн мэдээг Даваа гараг бүрт, сарын урьдчилсан мэдээг тухайн сарын 25-ны дотор, улирлын төлөвөөр жилд 2 удаа, тойм зөвлөмжөөр сар бүрийн 01, 11, 21 өдрүүдэд үйлчилдэг.

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОГТМОЛЖИЛТ
$$U_c = \frac{1}{2} \left(\frac{k}{K} 100\% + \frac{t}{T} 100\% \right); = 100$$

	Сумдын нэр	XII	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	Дүн
1	Сүхбаатар	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100
2	Баруунхараа	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100
3	Орхон	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100

4	Ерөө	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100
5	Орхонтуул	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100
6	Цагааннуур	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100
7	Мандал	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100
8	Баруунбүрэн	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100
9	Зүүнбүрэн	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100
10	Зэлтэр	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100
11	Хүдэр	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100
12	Бугант	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100
13	Хушаат	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100
	Дундаж	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100

Үйлчилгээний хүрээ, %, /Мэдээллээр үйлчлэх хүрээ ба хэлбэр/.

төрийн бүх байгууллага, ард иргэд, аж ауйн нэгжид.

Хэлбэр: бичвэр, ТВ, FM, электрон самбар, интернет, мобайль үйлчилдэг.

	Сумдын нэр	XII	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	Дүн
1	Сүхбаатар	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100%
2	Баруунхараа	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100%
3	Орхон	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100%
4	Ерөө	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100%
5	Орхонтуул	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100%
6	Цагааннуур	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100%
7	Мандал	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100%
8	Баруунбүрэн	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100%
9	Зүүнбүрэн	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100%
10	Зэлтэр	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100%
11	Хүдэр	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100%
12	Бугант	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100%
13	Хушаат	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100%
	Дундаж	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100

АҮ, БГҮ-ээс сэрэмжлүүлсэн байдал. Нийтдээ аймгийн хэмжээнд аюултай үзэгдлээс

сэрэмжлүүлэх мэдээгээг 18 удаа бичих нөхцөл бүрдснээс, 17 удаа сэрэмжлүүлэх мэдээ, 1 удаа урьдчилан сэргийлэх мэдээ бичиж үйлчилсэн байна.

$$Ser = \frac{n_u}{N_\Sigma} 100\%; \quad \text{үүнд: } Ser - \text{АҮ, БГҮ-ээс сэрэмжлүүлсэн эсэх, \%}$$

n_u -үүнээс тухайн СМ, УСМ-ээр үйлчилсэн АҮ, БГҮ-ийн тоо.

N_Σ -нийт болсон АҮ ба БГҮ-ийн тоо.

	Сумдын нэр	Үйлчлэх сэрэмжлүүлэг мэдээ	Үйлчилсэн байдал
1	Сүхбаатар	18	18
2	Баруунхараа	18	18
3	Орхон	18	18
4	Ерөө	18	18
5	Орхонтуул	18	18
6	Цагааннуур	18	18
7	Мандал	18	18
8	Баруунбүрэн	18	18
9	Зүүнбүрэн	18	18

10	Зэлтэр	18	18
11	Хүдэр	18	18
12	Бугант	18	18
13	Хушаат	18	18
	Нийт	234	234

АҮ, БГҮ-ээс сэрэмжлүүлсэн байдал: **Ser=221/221*100=100%**

ХААЦУ-ын салбар нь:

- Өвлийн бэлчээрийн цасны явуул судалгааны ажиглалтыг 17 сумын 45 зогсоол цэгт хийж, мал өвөлжилтийн тойм, зудын үнэлгээ хийж, зураглалд оруулан, ард иргэдэд үйлчилсэн
- Зудын эрсдлийн үнэлгээ, сарын өвөлжилтийн тойм, зудын мэдээгээр сайтанд тогтмол байршуулан, сумдын засаг даргын тамгын газар болон аймгийн засаг даргын тамгын газар онцгой байдлын газарт хүргүүлэн ажилласан.
- Хөрс гэсэх хугацаа, хөрсний хаврын угтвар ашигтай чийгийн урьдчилсан мэдээ зохиож, мэдээний таарц **89,7%-тай** буюу өмнө жилээс **0.1%-аар** ахисан.
- Хөрс гэсэх хугацааны явуул судалгаагаар 4,10-р сард 12 сумын 48 талбайд хөрсний угтвар чийгшил тодорхойлолж, дүн мэдээг нэгтгэн, зураглалд оруулж, засаг даргын тамгийн газар болон ХХААЖДҮГазар, сумдын ХАА-н тасгийн мэргэжилтэнгүүд, болон газар тариалан эрхэлдэг хүмүүст, тариаланчдын зөвлөгөөнд хөрсний чийгийн мэдээгээр үйлчилсэн.
- Сар бүрийн 11, 21,1 ны өдөр өртөө, харуулаас арав хоногийн агро дундаж мэдээг 36 удаа хүлээн авч, цасны дундаж зузаан, агаар, хөрсний температур, мал аж ахуйд зохиогдож буй ажилд цаг агаарын нөлөөллийг тогтмол бичиж сайтанд байршуулан
- Хиймэл дагуулын зурган мэдээнээс, цасан бүрхүүл 12 удаа, ургамлын бүрхэвч 3 удаа 10 хоног тутам татан авсан
- 2024оны өвөлжилийн тойм бичиж, аймгийн онцгой комисст болон www.selenge.tsag-agaar.gov.mn сайтанд байршуулж үйлчилсэн
- ХААЦУСХ-ээс гаргасан хадлан бэлчээрийн ургамлын ургац, улаанбуудай аарцанбололтонд орох хугацаа, ургацын урьдчилсан мэдээ, 6/20нд цочир хүйтрэлийн зөвлөмжөөр сайтанд байршуулж үйлчилсэн
- Бэлчээрийн төлөв байдлын ажиглалтаар 17 сумын 45 зогсоол цэгт хийж, 2024-2025 оны бэлчээрийн даац багтаамж тодорхойлон, хүснэгт, зураглал гарган аймгийн ХААГазар, сумдын ХАА-н тасгийн мэргэжилтэнгүүд болон сайтанд байршуулсан

№	Мэдээний төрөл	Байгууллага, аж ахуй нэгж, иргэд	Мэдээгээр үйлчилсэн хэрэглэгчдийн тоо
1	Хөрс гэсэх хугацаа, хөрсний хаврын угтвар ашигтай чийгийн урьдчилсан мэдээ	Аймгийн засаг даргын тамгийн газар ХХААЖДҮГазар, сумдын ХАА-н тасгийн	40

	Тариалтын өмнөх хөрс гэсэх, хөлдөх хугацааны хөрсний явуул судалгаа	мэргэжилтэнгүүд, тариаланчид, ард иргэдэд	
2	Өвлийн бэлчээрийн цасны явуул судалгаа	Аймгийн засаг даргын тамгийн газар ХХААЖДҮГазар, сумдын ХАА-н тасгийн мэргэжилтэнгүүд Алтанбулаг, Жавхлант сум, ОБГазар, иргэд	44
3	Хаваржилтын байдал		3
4	Арав хоногийн тойм, цас , ургамалжилтын зураг мэдээ		38
5	Бэлчээрийн даац багтаамж		27
6	Сарын зуншлагын тойм		6
7	2024 оны зуншлагын тойм мэдээ		4
8	Бэлчээрийн болон таримал ургамлын ургац, улаанбуудайн аарцанбололтонд орох үе шатны урьдчилсан мэдээ	ХХААЖДҮГазар, тариаланчид, малчид , сайтанд байршуулсан	16
9	хөрсний чийгшил, царцаа, мэрэгч, таримал болон бэлчээрийн ургамлын ургалтын тойм мэдээ		36
10	Хиймэл дагуулын мэдээ		15
Нийт			229

2.1.3 Нарийвчилсан мэдээ, 1 хоног, 5 хоногийн урьдчилсан мэдээг тасралтгүй, чанартай бичиж үйлчлэх.

2024 оны байдлаар: Цаг агаарын мэдээ мэдээллээр төр захиргааны байгууллага болон олон нийтэд хүргэх мэдээлэл үйлчилгээний ажил хэвийн явагдаж байна.

2024 оны урьдчилан мэдээлэх салбарын шинжилгээний ажлын гүйцэтгэл 98,6 % өмнөх оны шинжилгээний ажлын дүнтэй харицуулхад 0,7 %-иар өссөн байна. Үүнд: сэрэмжлүүлэг мэдээний ерөнхий дүн 2,6 %-иар, нарийвчилсан мэдээний таарц 2,1%-иар, хоногийн мэдээний таарц 3,7 %-иар, 1-5 хоногийн мэдээний таарц 2,4 %-иар тус тус өссөн нь шинжилгээний ажлын нэгдсэн дүн өсөхөд нөлөөлсөн байна.

Хагас хоногийн урьдчилсан мэдээний ирц, таарц

Сүхбаатар сумын цаг агаарын хагас хоногийн урьдчилсан мэдээг 365 удаа зохиож 95,8 %-ийн таарцтай буюу өмнөх оны дүнтэй харьцуулхад таарц 0,9 %-аар өссөн, ирц нь 100 %-тай буюу өмнөх оны дүнтэй харьцуулхад өөрчлөлтгүй байна.

Хоногийн урьдчилсан мэдээний ирц, таарц

Сүхбаатар сумын цаг агаарын хоногийн урьдчилсан мэдээг 365 удаа зохиож 92,7 %-ийн таарцтай буюу өмнөх оны дүнтэй харьцуулхад 0,3 %-аар өссөн, ирц нь 100 %-тай байна.

1-5 хоногийн урьдчилсан мэдээний ирц, таарц

Сүхбаатар сумын цаг агаарын 1-5 хоногийн урьдчилсан мэдээг 365 удаа зохиож 86,8%-ийн таарцтай буюу өмнөх оны дүнтэй харьцуулхад 0,1 %-аар өссөн байна.

2.1.4 Нислэгийн мэдээгээр үйлчлэх.

2024-оны байдлаар 34 онгоцонд цаг агаарын мэдээгээр үйлчилсэн байна.

ТАФ ТОИМ-ыг 61 удаа

Районы урьдчилсан мэдээг 34 удаа

Угталтын урьдчилсан мэдээг 21 удаа

Чиглэлийн урьдчилсан мэдээг 12 удаа тус тус бичиж нисэхийн цаг уурын төвд дамжуулсан байна. 2024 оны байдлаар: Нислэгт цаг агаарын мэдээгээр үйлчилсэн ажлын чанар 98,8% өмнөх оны дүнтэй харьцуулхад чанар 0,7%-аар буурсан байна.

2.1.5 Архивын баримт, тусгай хэрэгцээний мэдээгээр байгууллага, аж ахуйн нэгж, ард иргэдийн хүсэлтээр үйлчлэх.

Албан байгууллага, аж ахуй нэгж, ард иргэдэд захиаллагын дагуу 2024 оны жилийн эцсийн байдлаар төлбөртэй 10 мэдээ, төлбөргүй 13 нийт 23 удаа мэдээгээр үйлчилсэн байна.

2.1.6 Цаг агаарын тусгай хэрэгцээний урьдчилсан мэдээгээр хэрэглэгчдийн шаардлагад нийцүүлэн үйлчлэх.

Тусгай хэрэгцээний урьдчилсан мэдээгээр хэрэглэгчдийг үйлчилсэн байдал:

Цаг агаарын мэдээ мэдээллээр 58 аж ахуйн нэгжтэй, иргэдтэй гэрээтэй ажиллаж байна.

Атар теред ХХК, Арвин бэлчир ХХК, Их шинэст ХХК, Бамбууш ХХК, Их шинэстэй ХХК, Итгэл ХХК, Оргил ХХК, Бөмбөөлэй ХХК, Сэлэнгэ энерго ХХК, Сэлэнгэ АЗЗА ХХК, Хуримт шим ХХК, Шижир болор ХХК, Гацуурт, Гэгээлэг, Шинэбүрэн, Бугант минж, Бугант нандин, Бооцын тариа, Зэлтэр алтай, Суврага ургац, Анх тамир, Зэлтэр өгөөж, Зэлтэр зөгий, Түмэн буудай Гэрээт газруудаас ямар нэгэн гомдол ирээгүй тул гэрээний биелэлт хэвийн явагдаж байна.

Цаг агаарын урьдчилсан мэдээ, болон тойм зөвлөмжөөр нийт 26 засаг захиргааны нэгж байгууллагад үйлчлэж байна.

- - ИТХ
- - Аймаг сумын засаг дарга
- - Аймгийн тамгын газрын дарга
- - ХХААЖДҮГазар
- - Онцгой байдлын газар
- - Цагдаагийн газар
- - Статистикийн газар
- Цаг агаарын нөхцөл байдлын тодорхойлолтыг 17 аж ахуйн нэгж, төрийн байгууллагад нийт 23 удаа бичиж холбогдох газруудад шуурхай хүргүүлж ажилласан байна.

2.1.7 Архивын баримт, тусгай хэрэгцээний мэдээгээр байгууллага, аж ахуйн нэгж, ард иргэдийн хүсэлтээр үйлчлэх.

Албан байгууллага, аж ахуй нэгж, ард иргэдэд захиаллагын дагуу 2024 оны жилийн эцсийн байдлаар төлбөртэй 10 мэдээ, төлбөргүй 13 нийт 23 удаа мэдээгээр үйлчилсэн байна. /2.1.5-г давхардуулан оруулсан байна./

2.1.8 Ус, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх мэдээний чанарыг сайжруулах, аюултай болон гамшигт үзэгдлийн урьдчилан илрүүлэлтийг нэмэгдүүлэх.

Урьдчилан сэргийлэх мэдээ (УСМ), сэрэмжлүүлэх мэдээний (СМ) чанар, онч

2024 оны жилийн эцсийн байдлаар аюултай үзэгдэл болон гамшигт үзэгдлээс сэргийлэх мэдээ зохиох цаг агаарын нөхцөл 15 удаа бүрдсэнээс, СМ-ийг 15 удаа бичсэн байна.

Үүнд:

- Цочир хүйтрэлтээр 2 удаа
- Их бороо 5 удаа
- Их цас 3 удаа

Цасан шуургаар 5 удаа тус тус бичиж чанар нь 98,7 %-ийн таарцтай, онч 100 %, илрүүлэлт нь 100 % байна. Өмнөх оны дүнтэй харьцуулахад таарц 5,4%-аар, онч 2,4 %-аар өссөн, илрүүлэлт нь өөрчлөлтгүй байна. Сэрэмжлүүлэг мэдээний ерөнхий дүн нь 99,6 % өмнөх оны дүнтэй харьцуулахад 2,1 %-аар өссөн дүнтэй байна.

2.1.9 Ус, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс анхааруулах мэдээгээр үйлчлэх.

2024 оны жилийн эцсийн байдлаар анхааруулах мэдээг ард иргэд, аж ахуйн нэгж байгууллага, малчид, ногоочид, тариаланчид, жолооч тээвэрчидэд зориулан нийт 37 удаа бичсэн. Үүнд:


- Хүйтрэлт 7 удаа
- Цасан ба шороон шуургаар 6 удаа
- Цочир хүйтрэлт 2 удаа
- Салхи шуурга 3 удаа
- Их бороо 9 удаа
- Их цас 3 удаа
- Халалт 2 удаа
- Нойтон цас 3 удаа

Гол мөрний мөс цөмрөх, голын үер, шар усны үер 2 удаа тус тус бичиж хэрэглэгчдэд үйлчилсэн байна.

2.1.10 Цахим орчинд ус, цаг уур, байгаль орчны мэдээ, мэдээллээр ард иргэдэд үйлчлэх

Сэлэнгэ аймгийн УЦУОШТөв пейж хуудас:

Манай төв дээр ажиллаж байсан 5500 гариу дагагчтай Сэлэнгэ Ус Цаг Уур нэртэй пейж хуудасны админ нь ажлаас гарсан шалтгаанаар пейжийг шилжүүлэх боломжгүй болсон тул шинээр Сэлэнгэ цаг уурын төв нэртэй фэйсбүүк хаяг нээж, түүн дээрээ админ эрхээ өгч Сэлэнгэ аймгийн УЦУОШТөв нэртэй пэйжийг хөгжүүлээд жил гаран болж байна.



Бид одоогоор энэ 2 хуудас дээрээ бүх төрлийн мэдээллээ тогтмол байршуулж ажиллаж байна.

- Хагас хоногийн цаг агаарын урьдчилсан мэдээ 200 удаа
- Цаг агаарын 1 хоногийн цаг агаарын урьдчилсан мэдээ 200 удаа
- 1-5 хоногийн цаг агаарын урьдчилсан мэдээ 200 удаа
- 7 хоногийн цаг агаарын урьдчилсан мэдээ 40 удаа
- Сарын цаг агаарын төлөв 12 удаа
- Улирлын төлөв 12 удаа
- Цочир хүйтрэлтийн сэрэмжлүүлэг мэдээ 5 удаа
- Цасан шуурганы сэрэмжлүүлэг мэдээ 6 удаа
- Их борооны сэрэмжлүүлэг мэдээ 8 удаа
- Гол мөрний үерийн мэдээ 15 удаа
- Нойтон цасны анхааруулга мэдээ 3 удаа
- Хүйтрэлтийн анхааруулга мэдээ 2 удаа
- Хүчтэй салхины анхааруулга мэдээ-1 удаа
- Халтиргаа гулгааны анхааруулга мэдээ 3 удаа
- Их борооны анхааруулга мэдээ 5 удаа
- Цасан ба шороон шуурганы анхааруулга мэдээ 6 удаа
- Зудын эрсдлийн үнэлгээ- 1 удаа
- Агаарын чанарын мэдээ- 5 удаа
- Цасны хээрийн хэмжилтийн мэдээ-2 удаа
- Түймрийн эрсдлийн мэдээ- 15 удаа
- ХААЦУ-ын мэдээ/ Бэлчээрийн даац багтаамж, ургамлын ургалтын байдал, хөрсний чийгшлийн мэдээ- 6 удаа

Гол мөрний усны түвшин, үерийн мэдээ- үертэй үед буюу 14 удаа тус тус 756 мэдээ мэдээлэл нийтэлсэн. Дээрх мэдээллийг давхардсан тоогоор 57345 хүн үзэж мэдээ мэдээлэлийг түргэн шуурхай авсан байна.

Байгаль орчны шинжилгээний мэдээ мэдээллээр үйлчилсэн байдал:

- <http://selenge.tsag-agaar.gov.mn> сайтад агаарын чанарын агаарын сарын тойм мэдээ 12, агаарын арав хоногийн мэдээ 36, агаарын хоногийн дундаж мэдээ 759, гадаргын усны тойм мэдээ 12, хөрсний тойм 1 мэдээг байршуулсан.
- 192.168.100.13/currentweather/eDTS/login.asp хаягаар Сүхбаатар, Мандал АЧХ-ын азотын давхар исэл болон хүхэрлэг хийн 44010 мэдээ, PM10 тоосонцор 732, PM2.5 тоосонцор 732, гадаргын усны 13278, хаягдал усны 904, хөрсний агрохими 850, хөрсний хүнд металл 230 тоон өгөгдөл мэдээг цаг хугацаанд нь алдаагүй дамжуулсан.
- Цацрагийн түвшний өдөр тутмын 1464 мэдээг <https://eic.mn/radiation/> сайтад байршуулсан.

Нийт 63020 мэдээ алдаагүй цаг хугацаанд дамжуулсан байна.

Гол мөрний мөс цөмрөх, голын үер, шар усны үерийн мэдээг 20 удаа тус тус бичиж сум орон нутгийн фэйсбүүк групп болон “Сэлэнгэ Цаг Уур”, “Selenge zar” гэсэн хуудсуудаар дамжуулан мэдээгээр үйлчилсэн.

2.1.11 Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэр дээрхи гадаргын ус болон байгаль орчны төлөвийн мэдээллээр үйлчлэх түгээх, мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх


БОШЛ: Гадаргын усны сарын 12 мэдээ, Гадаргын усны химийн шинжилгээний элемент бүрийн 12087 мэдээ, Хаягдал усны сарын 12 мэдээ, Хаягдал усны химийн шинжилгээний элемент бүрийн 651 мэдээ, Агаарын чанарын сарын 12 мэдээ, арав хоногийн 36 мэдээ, хоногийн мэдээ 366, тав хоногийн 52 мэдээ, Сүхбаатар сумын агаарын чанарын харуулын азотын давхар исэл, хүхэрлэг хий 2254, нарийн болон том ширхэгт тоосонцорын 366 мэдээ, Мандал сумын агаарын чанарын харуулын азотын давхар исэл, хүхэрлэг хий гэсэн 2 төрлийн 752 мэдээ

Цацрагийн тунгийн чадлын 8, 20 цагийн агаар хөрсний 1464 мэдээ, Тунадасны шинжилгээний 6 төрлийн 203 мэдээгээр үйлчилж байна.

Ус судлал: 10 харуулын өдөр тутмын ажиглалтын нийт 1820 мэдээ дамжихаас 1814 мэдээ цас мөсний зузаан, мөсний үзэгдлийн 180 мэдээ дамжихаас 180 мэдээ алдаа дутагдалгүй дамжигдсан байна. Энэ нь тухайн жилийн мэдээлэл үйлчилгээний ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл нь 99,7%-тай дүгнэгдэж байна.


К	Сумын нэр	Харуулын нэр	Харуулын индекс	01	02	03	04	05	06	07	08	09	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30
	Зүүнбүрэн	Сэлэнгэ	20321	09/01	09/02	09/03	09/04	09/05	09/06	09/07	09/08	09/09	09/10	09/11	09/12	09/13	09/14	09/15	09/16	09/17	09/18	09/19	09/20	09/21	09/22	09/23	09/24	09/25	09/26	09/27	09/28	09/29	09/30
	Сүхбаатар	Сэлэнгэ	20322	08/37	08/27	08/26	08/39	08/35	08/44	08/31	08/45	08/35	08/21	08/43	09/07	08/39	08/23	08/47	08/23	09/05	08/44	08/47	08/22	08/35	08/24	08/24	08/29	08/46	08/44	08/25	08/48	08/40	08/35
	Орхонтүл	Орхон	20323	09/01	09/02	09/03	09/04	09/05	09/06	09/07	09/08	09/09	09/10	09/11	09/12	09/13	09/14	09/15	09/16	09/17	09/18	09/19	09/20	09/21	09/22	09/23	09/24	09/25	09/26	09/27	09/28	09/29	09/30
	Сүхбаатар	Орхон	20324	08/37	08/28	08/26	08/38	08/36	08/45	08/55	08/46	08/34	08/21	08/45	08/44	08/39	08/25	08/48	08/25	08/26	08/45	08/46	08/23	08/35	08/25	08/24	08/32	09/09	08/41	08/22	08/32	08/38	08/28
	Ерөө	Ерөө	20325	09/01	09/02	09/03	09/04	09/05	09/06	09/07	09/08	09/09	09/10	09/11	09/12	09/13	09/14	09/15	09/16	09/17	09/18	09/19	09/20	09/21	09/22	09/23	09/24	09/25	09/26	09/27	09/28	09/29	09/30
	Хүдэр	Хүдэр	20326	08/20	08/25	08/25	08/40	08/25	08/21	08/20	08/37	08/28	08/23	08/17	08/33	08/19	08/37	08/16	08/21	08/17	08/10	08/21	08/20	08/19	08/18	08/21	08/19	08/20	08/28	08/41	08/23	08/27	08/27
	Баруунхараа	Хараа	20327	09/01	09/02	09/03	09/04	09/05	09/06	09/07	09/08	09/09	09/10	09/11	09/12	09/13	09/14	09/15	09/16	09/17	09/18	09/19	09/20	09/21	09/22	09/23	09/24	09/25	09/26	09/27	09/28	09/29	09/30
	Дулаанхаан	Ерөө	20328	09/01	09/02	09/03	09/04	09/05	09/06	09/07	09/08	09/09	09/10	09/11	09/12	09/13	09/14	09/15	09/16	09/17	09/18	09/19	09/20	09/21	09/22	09/23	09/24	09/25	09/26	09/27	09/28	09/29	09/30
	Зэлтэр	Зэлтэр	203146	09/01	09/02	09/03	09/04	09/05	09/06	09/07	09/08	09/09	09/10	09/11	09/12	09/13	09/14	09/15	09/16	09/17	09/18	09/19	09/20	09/21	09/22	09/23	09/24	09/25	09/26	09/27	09/28	09/29	09/30
	Бутант	Ерөө	203174	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Нийт			9/10	9/10	9/10	9/10	9/10	9/10	9/10	9/10	9/10	9/10	9/10	9/10	9/10	9/10	9/10	9/10	9/10	9/10	9/10	9/10	9/10	9/10	9/10	9/10	9/10	9/10	9/10	9/10	9/10	9/10

- Гол мөрний мөс цөмрөхөөс сэрэмжлүүлэх, үерийн анхааруулга мэдээг – 20 удаа
- Голуудын усны түвшний тойм мэдээг – 32 удаа тус тус байршуулсан.



Анхааруулга болон сэрэмжлүүлэг, тойм мэдээг бичиж зарласан байдал:

- Гол мөрний мөс цөмрөх, голын үер, шар усны үерийн мэдээг 20 удаа тус тус бичиж ард иргэд, аж ахуйн нэгж байгууллага, малчид, ногоочид, тариаланчдад үйлчилсэн.
- Голын үерийн сэрэмжлүүлэг мэдээг, сумдын урсдаг самбар, зарлалын самбаруудаар нийтдээ 20 удаа үйлчилсэн.
- Сар бүрийн 20-нд арав хоногийн тойм мэдээгээр тамгын газарт 12 удаа үйлчилсэн.



- Сэлэнгэ аймгийн ОБГазартай хамтран голуудын усны үер, мөсний зузааны сэрэмжлүүлэг мэдээг бэлтгэн байгууллагуудын фэйсбүүк хуудас болон бусад зарын группуудээр 2 удаа дамжуулсан.
- Сэлэнгэ аймгийн онцгой байдлын комисст голуудын үерийн талаар цаг тухай бүрт мэдээллэж хамтран ажилласан.
- Сэлэнгэ аймгийн ОБГазарт үерлэсэн голуудын сэрэмжлүүлэг мэдээгээр үйлчилсэн.

www.selenge.tsag-agaar.gov.mn сайтад: Гол мөрний мөс цөмрөхөөс сэрэмжлүүлэх, үерийн анхааруулга мэдээг–3 удаа, голуудын усны түвшний тойм мэдээг–32 удаа тус тус байршуулсан.

2.2 Хүрээлэн буй байгаль орчны төлөв байдалд хяналт тавьж үнэлэх, судлах ажлын хүрээг өргөжүүлэх

2.2.1 Химийн хорт болон аюултай бодис ашиглах аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авах

2024 оны байдлаар: 2024 оны 8 дугаар сарын 26-нд emongolia.mn апплекейшн ашиглан байгууллагын даргын тоон гарын үсгээр нэвтэрч БОШЛ-ын байгаль орчны ерөнхий үнэлгээ хийх мэдээллийг бүрдүүлэн хүсэлт өгсөн. Хүсэлтийн хариуг Сэлэнгэ аймгийн байгаль орчны мэргэжилтэн Ц.Бүрэнбаатар 2024 оны 11 дүгээр сарын 27-нд гаргаж өгсөн. БОШЛ-ийн химийн бодисын ашиглалт, хадгалалтын байдал, ажлын байрандаа дүгнэлт гаргуулах УЦУОШТөвийн даргын 07/200 тоотоор хүсэлтийг 2024 оны 10 дугаар сарын 31-нд хүргүүлэн улсын ахлах байцаагчийн дүгнэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 01-нд БОАЖГ-ын 01/29-01/068/01 тоотоор хүлээн авсан. БОАЖЯ-руу байгаль орчны ерөнхий үнэлгээ хийлгэх бичиг баримтуудаа цахимаар илгээсэн байгаа.

2.2.2 БОАЖСайдын 2018 оны А/479 дүгээр тушаалаар батлагдсан “Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах журам”-ын дагуу хийж үр дүнг аймгийн засаг дарга болон холбогдох газруудад хүргүүлсэн байх

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2023 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн А/120 тоот захирамжаар агаарын бохирдолын эх үүсвэрийн нэгдсэн тооллогыг зохион байгуулахад шаардлагатай 4,505,200.00 (Дөрвөн сая таван зуун таван мянга хоёр зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргуулж УЦУОШТөвийн байгаль орчны шинжилгээний лабораторит орчны бохирдлын эх үүсвэр, хаягдлын тооллогын мэдээллийн санд мэдээ шивэж мэдээллийн сан үүсгэхэд шаардлагатай өндөр хурдны /нөүтбүүк/ компьютерийг 3,149,900.00 төгрөгийн үнэтэй Dell Inspiron 3520 i7-1255U 8GB 512GB SSD 120Hz FHD шаардлага хангасан үзүүлэлт бүхий нөүтбүүкийг “РС МАЛЛ” цахилгаан барааны их дэлгүүрээс худалдан авалтыг хийж авсан.

“Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл хийх журам”-ын дагуу аймгийн засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/610 тоот захирамжаар томилогдсон ажлын хэсэг Сэлэнгэ аймгийн хэмжээнд агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэл явуулах, агаарын чанарыг тодорхойлох, агаарт ялгарч буй бохирдуулагч бодисын ялгарлыг тооцож гаргах ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд 138 аж ахуйн нэгжийн усан халаалтын болон уурын зуухны 6324 өгөгдөл, 13645 галлагаатай айл өрхийн 586735 өгөгдөлийг мэдээллийн санд бүрэн оруулж агаарт хаягдах бохирдуулагчдын хэмжээг гаргалаа.

Ердийн галлагаатай 3-15 квт хүртэл хүчин чадалтай зуух хэрэглэдэг 13645 айл өрх тоологдож 23509 тн нүүрс, 73709 м³ мод түлш хэрэглэсэн нь өмнөх оноос нүүрс 30.2%-иар, модны хэрэглээ 31.1%-иар тус тус багассан байгаа ч 2023 онд 4394.3 тн болж өмнөх

оноос 205.3 тонноор их ялгарал үүссэн байна. Галлагаатай айл өрхийн ялгарал хамгийн их нь Мандал сум буюу 1436.5 тонн байсан бол хамгийн бага ялгаралтай сумаар Орхон 38.4 тонн хүрсэн байна.


Сэлэнгэ аймгийн агаарын бохирдолын эх үүсвэрийн нэгдсэн тооллого

Монгол Улсын “Агаарын тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 8.1.5 дахь заалт, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2018 оны 11 сарын 30-ний өдрийн А/479 дугаар тушаалаар батлагдсан “Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл хийх журам”-ын дагуу аймгийн засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн А/610 тоот захирамжаар томилогдсон ажлын хэсэг Сэлэнгэ аймгийн хэмжээнд агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэл явуулах, агаарын чанарыг тодорхойлох, агаарт ялгарч буй бохирдуулагч бодисын ялгарлыг тооцож гаргах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Агаар бохирдуулах эх үүсвэрийн бага, дунд, том оврын уурын зуухыг сумдаар явж тоолох ажлын хэсэгт УЦУОШТөвийн БОШЛ-ын агаар, ус хариуцсан инженер С.Цэнджав, М.Өнөржаргал, жолооч Ц.Цэрэндорж нар хамтран агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллогыг аймгийн Засаг Даргын А/610 захирамжийн дагуу 2023 оны 12 дугаар сарын 12-ноос эхлэн Сүхбаатар, Алтанбулаг, Шаамар, Мандал, Баянгол, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг, Ерөө, Жавхлант, Хүдэр, Хушаат, Сант, Орхон, Баруунбүрэн, Орхонтуул, Сайхан сумдаар 2024 оны 1 дүгээр сарын 5 хүртэл хийсэн.

Газар дээр нь зуухны тооллого хийж буй байдал.





2022 онд суурин эх үүсвэрээс агаарт ялгарч байгаа хийнүүд 2021 онтой харьцуулахад хүхэрлэг хий, нийт тоос, азотын давхар исэл, нийт тоос, том ширхэглэгт тоосонцор PM10 болон нарийн ширхэглэгт тоосонцор болох PM2.5, нүүрстөрөгчийн дутуу ислийн хэмжээ 314-1805 тонноор ихсэж байсан бол 2023 онд өмнөх оноос агаарт хаягдаж буй хүхэрлэг хий 241 тонноор багасаж бусад үзүүлэлтүүд нь 520-2829 тонноор өссөн байна.



Аймгийн хэмжээнд суурин эх үүсвэрээс агаарт хаягдаж байгаа анхдагч бохирдуулагчийн хэмжээ 2018 онд 5801, 2019 онд 16416 тонн болж 2.8 дахин их гарч байсан. 2020-2021 онд 344-2857 тонноор бууран 2022-2023 онд өмнөх оноосоо 4117-5227 тонноор өссөн байна.

В.Агаар бохирдуулагч хөдөлгөөнт эх үүсвэрийн тооллогын судалгаа.


2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар чиргүүл нэмэгдсэн дүнгээр 24126 авто тээврийн хэрэгсэл авто тээврийн үндэсний төвийн оношлогоонд хамрагдсан байна.

Сэлэнгэ аймгийн тээврийн хэрэгслийн судалгаа /ангилалаар/

	Суудал	Ачаа	Автобус	Тусгай	Механизм	Чиргүүл	Мотоцикль
2019 он	9069	5418	151	105	251	187	506
2020 он	10391	6207	278	142	401	415	561
2021 он	12739	7104	288	148	520	409	455
2022 он	11644	6767	244	148	511	380	433
2023 он	14074	7668	279	199	700	419	499

2023 онд өмнөх оноос нийт 3730 тээврийн хэрэгслээр өссөн бөгөөд энэ нь уул уурхайд ашиглагдаж буй машин механизм тоологдсонтой холбоотой байна.

Тээврийн хэрэгслийн харьцуулсан судалгаа /түлшний төрөл/



Нийт тээврийн хэрэгслийг түлшний төрлөөр ангилан авч үзвэл 2014 оноос бензин хөдөлгүүрт тээврийн хэрэгслийн тоо 1826-аар, дизель хөдөлгүүрт тээврийн хэрэгслийн тоо 2701-ээр тус тус өссөн байна.

Тээврийн хэрэгслийн агаар бохирдуулагч бодисын ялгарлын хэмжээ 2019-2023 он

Он	Нийт тоос	PM10	PM2.5	CO	Метан бус дэгдэмхий органик нэгдэл	NH3
2019	180.792	123.1	123.12	123.12	123.12	123.124
2020	223.02	223	223.02	223.02	223.02	223.02
2021	258.2	258.2	258.2	258.2	258.2	258.2
2022	162.9	162.9	162.9	162.9	-	162.9
2023	193.972	193.972	193.972	193.972	-	193.972


Хөдөлгөөнт эх үүсвэрээс гарах агаар бохирдуулагч бодисын ялгарлын хэмжээг 2019 онтой харьцуулахад 2020 онд 40%, 2021 онд 70%, 2022 онд 2.2%, 2023 онд 7.3%-иар тус тус өссөн байна.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2023 онд гарсан ой хээрийн түймрийн судалгаа


2023 оны байдлаар Түшиг сум Ар нуга баг “Боот” гэдэг газарт 30 га хээр, Ерөө сум Буурагчин багийн Цагаа тохойд 25 га хээр, Баянголд 15 га хээр, Шаамар сумын Дэлгэрхаан баг Усжуулах гэдэг газарт 2 га хээр, Ерөө сум Буургачин 2 дугаар багийн Асгатын ам гэдэг газарт 25 га ой, Жавхлант сумын Бумбат багийн “Ханангийн энгэр”-т 200 га хээр, Хүдэр сумын Тарвагатай багийн “Сэвсүүл” гэдэг газар 30 га хээр, Баянгол сумын Баян 2 дугаар баг Эрэнгийн мухар гэх газар 0.5 га хээр, Ерөө сумын Буурагчин багийн “Цонхлонгийн даваа” гэдэг газар 1 га хээр, Мандал сум Хэрх 4 баг Баавгайтын ам гэдэг газар 0.7 га хээр, Ерөө сум Бугант баг "Их үлэлэй гол" гэдэг газар 5 га ой, 5 га хээр, Ерөө сум Бугант баг "35-ын ам " гэдэг газар 30 га ой нийт 35 га ойн, 309.2 га хээрийн түймэр гарсан байна.

Аймгийн хэмжээнд нийт 2020 онд 19 ой хээрийн түймэр гарснаас 17 ой хээрийн түймрийн бүртгэлийг мэдээллийн системд орууллаа. Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Сайдын ам, Баянцагаан 2-р багийн Монгол улсын хилийн 708-р тэмдэгтийн орчим гарсан 2 түймэр 1 га газар хүрээгүй учир түймэр гараагүйд тооцож түймрийн бүртгэлд оруулаагүй болно. 2022 онд аймгийн хэмжээнд 23 ой хээрийн түймэр гарснаас 21 ой хээрийн түймрийн бүртгэлийг мэдээллийн системд оруулсан бөгөөд Алтанбулаг сумын Суврага 2

дугаар баг Номт амралт Мандал сумын Тарни 8 дугаар багийн “Дарьтын эх” гэдэг газар гарсан 2 түймэр 1 га газар хүрээгүй учир түймэр гараагүйд тооцож түймрийн бүртгэлд оруулаагүй болно. 2023 онд нийт 12 ой хээрийн түймэр түймрийн мэдээлийг мэдээлийн санд оруулсан.



Аймгийн хэмжээнд гарсан ой хээрийн түймрээс агаарт нүүрстөрөгчийн дутуу исэл 2020 онд 12044.2 тонн байсан бол 2021 онд 5536.7, 2022 онд 3714.5, 2023 онд 464.7 тонн буурсан байна.



Сэлэнгэ аймгийн хэмжээнд ой хээрийн түймэр жилээс жилд багасаж агаарт хаягдах бохирдуулагчийн хэмжээ 2020, 2021 онтой харьцуулахад 26.3-27.3 дахин буурч байгаа нь бороо цас их орж байгаатай холбоотой байна.

- Агаарын бохирдолын эх үүсвэрийн нэгдсэн тооллогыг 17 сумаар хийж нийт 138 аж ахуйн нэгжийн усан халаалтын болон уурын зуухны 6324 өгөгдөл, 13645 галлагаатай айл өрхийн 586735 өгөгдөлийг мэдээллийн санд бүрэн оруулж агаарт хаягдах бохирдуулагчдын хэмжээг гаргалаа.
- Ердийн галлагаатай 3-15 квт хүртэл хүчин чадалтай зуух хэрэглэдэг 13645 айл өрх тоологдож 23509 тн нүүрс, 73709 м³ мод түлш хэрэглэсэн нь өмнөх оноос нүүрс 30.2%-иар, модны хэрэглээ 31.1%-иар тус тус багассан байгаа ч 2023 онд 4394.3 тн болж өмнөх оноос 205.3 тонноор их ялгарал үүссэн байна. Галлагаатай айл өрхийн ялгарал хамгийн их нь Мандал сум буюу 1436.5 тонн байсан бол хамгийн

бага ялгаралтай сумаар Орхон 38.4 тонн хүрсэн байна.

- Хөдөлгөөнт эх үүсвэр болох автомашин 2022 онд 20396, 2023 онд 24126 тоологдож агаарт хаягдах бохирдуулагчийн хэмжээ 969.9 тонн хүрсэн ба өмнөх оноос 155.4 тонноор өссөн байна.
- Ой хээрийн түймэр 12 бүртгэгдэж агаарт хаягдах бохирдуулагчийн хэмжээ 717.6 тонн буюу өмнөх оноос 5107 тонноор бага ялгарал үүссэн байна.

Бага, дунд оврын уурын зуухны тоо 2019 онд газар дээр нь тоолох үйл ажиллагааг явуулахад 160 байсан бол түүнээс хойш утсаар асууж судалгаа мэдээлийн авч байх хугацаанд жил бүр хасагдаж 2022 онд 102 болон буурч байсан тоо 2023 оны тооллогоор 135 болсон нь мэдээлэлээ аж ахуйн нэгж, иргэд буруу өгдөг байна.

2.2.3 Хилийн усны гэрээ хэлэлцээрийн дагуу 8 дугаар сард Сэлэнгэ мөрний 12 дугаар точик, Оросын талаас Наушка өртөө орчмоос дээж авч шинжилгээ хийн мэдээг солилцох

Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын ЭААХХХХ-ын гаалийн улсын байцаагч Б.Баярцэцэгтэй хамтран 2024 оны 8 дугаар сарын 7-8-ны хооронд Сэлэнгэ мөрөн, Хиагт, Цөх, Хяраан, Зэлтэр голуудаас хилийн усны сорьцыг аван үр дүнг өгөн ажиллав. Мөн ОХУ-ын Буриад улсын Хиагт өртөөний цаг уурын станцын дарга Наташа болон усны ажиглагч Сергей нартай хамтран 2024 оны 08 дугаар сарын 20-нд төмөр замын Наушка өртөөний орчим Сэлэнгэ мөрнөөс дээж авч БОХЗТЛабораторид гол болон биоген, нефтийн бүтээгдэхүүн тодорхойлох сорьцыг хүргүүлэн БОШЛ нь зэрэгцээгээр усны гол ион болон биогены элементийг тодорхойлон үр дүнг төв рүү илгээсэн.

2.2.4 Аймгийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн агаар, ус, хөрсний чанарт хяналт шинжилгээ хийх

Усан бассейн, Сэлэнгэ Цэнгэг ус ОНӨААТҮГ, “Цемент Шохой” ХХК, “Мон кварц” ХХК, “Бороо гоулд” ХХК, “Сайхан цэвэр ус” үйлдвэр, Орхонтуул сумын Рашаант тосгоны ЕБС, иргэн Даваадорж, Батбилэг, Бажаргал, “Ану зоог”, цайны газар, иргэн Халзан, “Green natur land” ХХК, Дархан-уул аймгийн “Төмөрлөгийн үйлдвэр” ХХК, “Юнигаз” АХЦС, “Дашваанжил” АХЦС, “Юнигаз” АХЦС, “Хүннү стил” ХХК, “Цэлмэг Хүдэр” ХХК, “Дэвжих таван хан” ХХК, “Сод Монгол” группын ШТС, “Тэс Петролиум” ШТС, Орхонтуул сумын засаг даргын тамгын газар, “Монтай-Эрдэнэ” ХХК, Политехникийн коллеж, “Сартуул орд” ХХК, “Сэлэнгэ-Энерго” ОНӨААТҮГ, “Аш нэмэх” хоршоо, “Маш Отог” ХХК, БГДЭ нөхөрлөл, Дархан газрын тосны агуулахын харьяа ШТС, “Их хаадын түүчээ” ХХК, “Ойн нарс” ХХК, Маргадочирваань ХХК, Ерөө сумын Бугант тосгоны 2-р цэцэрлэг, “Хандгайт гол” ХХК, “Ургац Агро” ХХК, УБТЗ-ын төмөр бетон дэрний үйлдвэр, “Гацуурт Хүнс” ХХК, “Чамин Алт” ХХК, “Гүнж Аялгуу” ХХК, Ерөө сумын Бугант тосгоны Ерөнхий боловсролын сургууль, “Спирт бал бурам” ХК зэрэг нийт дөчин ААН-д 150 агаар, 124 ус, 119 хөрсний химийн шинжилгээг хийж, үр дүнг хүргэж байгууллагын дансанд арван долоон сая долоон зуун гучин мянга таван зуун төгрөгийг төвлөрүүлсэн байна.

ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ АРГА, ХЭМЖЭЭ

/САНХҮҮ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ТӨСВИЙН УДИРДЛАГА БОЛОН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ/.

3.1.Төсвийн тухай хуулийн хүрээнд төсвийн шууд захирагчийн бүрэн эрхийг
хэрэгжүүлж, төсөв санхүүгийн хэвийн үйл ажиллагааг хангах

3.1.1 Төсвийн төсөл, дунд хугацааны төсөөлөл, төсвийн тодотголыг үнэн зөв
үндэслэлтэй боловсруулж ЦУОШГ-т хүргүүлэх, ажилтнуудад ил тод мэдээлэх

2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөлөлийг төсвийн тухай хуульд заасны дагуу хийж төсвийн хуваарийг гарган, хөрөнгө оруулалтын санхүүжилтийн үнэлгээг хийж эрэмбэлж сангийн яамны сайтад байршуулж тогтоосон хугацаанд ЦУОШГазарт явуулсан болно.

3.1.2 Санхүүгийн мэдээ, тайланг үнэн зөв хийж НББОУС болон үндэсний стандартын дагуу хугацаанд нь үнэн зөв, бүртгэж тайлагнах.

Тайлангийн хугацаандаа 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан 2024 оны хагас жил, 3-р улирлын тайлангуудыг ЦУОШГазарт заасан цаг хугацаанд нь явуулсан ба сар, улирлын тайлан санхүүжилтийн мэдээг цаг хугацаанд гаргаж холбогдох газарт хүргүүлэн ажиллав.

Шилэн дансны хууль хэрэгжсэнтэй холбогдуулан мэдээллийг холбогдох журмын дагуу дараа сарын 7,8-ны дотор байршуулан хэрэгжилтийг ханган ажиллаж ирлээ. Төсвийн ил тод байдал, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг сар бүрийн 2-ны дотор ЦУОШГ төсвийн гүйцэтгэлийн нийт 12 мэдээг хүргүүлж мөн байгууллагын ил тод мэдээллийн самбарт, 1-р сараас эхлэн сар бүрийн 5-ны дотор санхүүгийн тайлан мэдээ, урсгал төсвийн гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төсөөлөл, 2024 оны төсөв, аудит тайлан, аудитын зөвлөмжийн биелэлт зэрэг үндсэн мэдээллийг бев сайтанд шинэчлэн тус тус тавьж байгаагийн дээр байгууллагын сар бүрийн ажилчдын хуралд танилцуулах, санхүүгийн мэдээллийн самбарт хэвлэн тавьж санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллаж байна.

Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 01-р сарын 11 ны өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам болон бусад хууль тогтоомж, эрх зүйн актуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Шилэн дансны тухай хуулийн 6-р зүйлийн 6.1-6.3-д заасан мэдээлвэл зохих 27 төрлийн мэдээлвэл зохих 171 мэдээг цаг хугацаанд нь мэдээллийг тогтмол нийтэд ил тод мэдээлж ажилласан.

Шилэн дансны цахим хуудсаар тогтмол болон 7 хоногийн дотор мэдээлвэл зохих 45 мэдээ болон 758,7 сая төгрөгийн мэдээллийг цахимаар болон самбараар мэдээлж ажилласан. Мөн шилэн дансны улирлын тайлан мэдээг цаг хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

3.1.3 Төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зөв зарцуулж, өр авлага үүсгэхгүй ажиллах.

Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 388 дугаар тогтоолоор төсвийн хэмнэлтийн горимд шилжин ажиллаж өр авлага үүсгэхгүй байх арга хэмжээ авч, төсвийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг үүрэг болгосон. 2024 оны 2-р улирлын байдлаар нийт төсвийн санхүүжилтийн 78.3% цалингийн зардал, 21.7% нь үйл ажиллагааны зардал, урьд онтой харицуулахад төсвийн санхүүжилт урьд оноос 73,8%-иар өссөн. Энэ нь цалин хөлс нэмэгдсэн, сайдын багцаас компьютер тоног төхөөрөмжөөр хангах, сумдын өртөөдийг эко 00-оор хангах санхүүжилтийг шийдвэрлэсэнтэй холбоотойгоор өссөн төсөвтэйгээр ажиллаж байна

2023 оны санхүүгийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийг залруулах давтахгүй байх акт, албан шаардлага зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган батлуулж ажиллаж байна.

3.1.4 Бараа материал болон эд хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр хийж эд хариуцагчид тавих хяналтыг сайжруулах

Байгууллагын үндсэн хөрөнгийн тооллогыг тус төвийн даргын А/54 тоот тушаалаар томилогдсон 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хийж гүйцэтгэсэн бөгөөд тооллогоор үндсэн хөрөнгийг биечлэн үзэж хөрөнгө бүрийн чанар байдал хадгалалт хамгаалалт үнэ хүчин чадал зэргийг биечлэн тулган үзэж тооллогын бүртгэлд тэмдэглэн агуулахын эмх цэгцийг сайжруулан, үндсэн хөрөнгийн бүртгэлийг статистикийн мэдээ мэдээллийг гарган ТӨБЗГазар болон Цаг уур орчны шинжилгээний газарт хүргүүлсэн болно.

2023 оны 12-р сарын 27-ны тооллогын дүнг хэлэлцээд тооллого хийж гүйцэтгэхэд бүртгэлд 363,282,534,09 төгрөгийн барилга байгууламж, 260,508,000 төгрөгийн газар, 104,767,573,78 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 15,281,560 төгрөгийн тавилга эд хогшил, 275,565,346,09 төгрөгийн тоног төхөөрөмж, 80,300,940,35 төгрөгийн эргэлтийн хөрөнгө тооллоо.

Тооллогоор үндсэн хөрөнгийг биечлэн үзэж хөрөнгө бүрийн чанар байдал хадгалалт хамгаалалт, үнэ, хүчин чадал зэргийг биечлэн тулган үзэж тооллогын бүртгэлд тэмдэглэн агуулахын эмх цэгцийг сайжруулан, үндсэн хөрөнгийн бүртгэлийг өмчийн бүртгэлийн программд оруулан хянуулж Цаг уур орчны шинжилгээний газарт хүргүүлсэн болно. Тус төвийн өмч хамгаалах байнгын зөвлөл нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2, төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батласан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7.1 дахь заалтын дагуу 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдөр хэлэлцэн шийдвэрлэж дараах саналыг хүргүүлж ажилласан.

Тус төвийн үндсэн хөрөнгөнд бүртгэлгүй үлдэх өртөггүй нийт 43 нэр төрлийн 112 ширхэг 4,238,120 төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг УЦУОШТ-ийн эргэлтийн хөрөнгөөс хасч актлах шийдвэрийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлөөр гарган холбогдох баримт материалыг ТӨБЗГазарт хүргүүлэн шийдвэрлүүлсэн.

ТӨБЗГазрын 2023 оны 19 дүгээр тогтоол, ЦУОШГазрын даргын 2023 оны 03-р сарын 10 ны А/31 тоот тушаалаар 8 төрлийн 21 ширхэг 5166950 төгрөгийн анхны өртөг бүхий хөрөнгийг 3450,000 төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг шинэчлэн бүртгэж тайлан бүртгэлд тусган биелэлтийг албан тоотоор хүргүүлж ажилласан.

2023 оны жилийн эцсийн тайлангийн аудитаар аймгийн аудитын газраас ирж хөрөнгийг нүд үзэн тоолж заавар зөвлөмж өгсний дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Төрийн болон Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн 2023 оны жилийн эцсийн хөрөнгийн бүртгэлийг программд оруулан хөдөлгөөнийг хийж бүртгэлжүүлж, ТӨБЗГазраас ирсэн Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг сунган, 2023 оны биелэлтийг дүгнүүлж 88 хувь буюу хангалттай үнэлэлт дүгнэлт авч ажилласан болно. ТӨБЗГазраас өгсөн зөвлөмжийн дагуу зөрчилтэй байгаа газрын асуудлыг шийдвэрлэхээр ГХБХБГазар болон Хүдэр сумын Засаг даргын тамгын газартай хамтарч ажиллаж байна.

3.ЦУОШГазраас үнэ төлбөргүй хүлээн авсан 69,656,480 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тусгай зориулалттай материал, хангамжийн материалуудыг нэг бүрчлэн тоолж тайланд бүрэн тусгасан болно.

3.2 БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ, ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН НИЙГМИЙН БАТАЛГАА МАНЛАЙЛЛЫГ ХАНГАХ

3.2.1 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт

- Тус төв дээр 2024 онд хяналтанд авсан 48 тогтоол, шийдвэр захирамж, тушаал, албан даалгавар хэрэгжиж байгаа бөгөөд нэмж Монгол улсын байгаль орчин аялал жуулчлалын сайдын 1 тушаал, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 1 тогтоол, Цаг уур орчны шинжилгээний газрын даргын 9 тушаал, Сүхбаатар сумын Засаг даргын 1 захирамж хяналтандаа авлаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Хэрэгжилт 100%

-Төрийн албаны шинэчилсэн хуулиар 1 удаа сургалт зохион байгуулж засгийн газрын 258 тоот тогтоолын хэрэгжилт 100% –тай байна.

-Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн холбогдох 6 заалтын ажлын гүйцэтгэл 100% байна.

-Сэлэнгэ аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт холбогдох 9 заалтын хэрэгжилт 100% байна.

- 2024 онд төв нь 80 хүний орон тоотой үүнээс 3 албан хаагч нь хүүхэд асрах чөлөөтэй, 4 албан хаагч өндөр насны тэтгэвэр гарах эрх үүсэн ажлаас чөлөөлөгдсөн, 5 албан хаагчийг ажилд шилжүүлэн томилсон, 6 албан хаагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна

- 2024 онд Ус цаг уурын байгууллага үүсэж хөгжсний 100 жилийн ой, Сэлэнгэ аймгийн УЦУОШТөв байгуулагдсаны 60 жилийн ойг тохиолдуулан Байгаль орчны салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа албан хаагчдын шагналын тодорхойлолтыг бичин хүргүүлсэн байна. Үүнд Төрийн одон медалиар ахмад ажилтан 8 хүн, 9 албан хаагч, Байгаль орчны “Тэргүүний ажилтан”аар 7 албан хаагч, Байгаль орчны

“Жуух бичиг”ээр 7 албан хаагч, “Нягтлан бодох бүртгэлийн Тэргүүний ажилтан”аар 1 албан хаагч, Сэлэнгэ аймгийн ИТХ-ийн “Хүндэт тэмдэг”ээр 5 албан хаагч, “Хүндэт Өргөмжлөл”өөр 2 албан хаагч, Сэлэнгэ аймгийн Засаг даргын “Жуух бичиг”ээр 17 албан хаагч, ЦУОШГазрын “Жуух бичиг”ээр 4 албан хаагч, Сүхбаатар сумын “Жуух бичиг”ээр 11 албан хаагч, Хамтран ажилладаг байгууллагуудын шагналаар 13 албан хаагчийн шагналын тодорхойлолтыг бичин холбогдох шагналаар шагнуулсан байна.

3.2.2 Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар

Сэлэнгэ аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан Удирдлагын академийн багш нарын хамтарсан Төрийн албаны шинэтгэлийн бодлого, сургалтын тогтолцоо, ёс зүйн тухай сургалтанд 1 дүгээр сард хамрагдав. Хүний тоо 2, 4 цаг

-Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, түүний нийтлэг ойлголтын талаар сургалтыг Доктор М.Цэрэнбат 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдөр орж 15 ажилтан оролцсон.

Төвийн ёс зүйн зөвлөл нь ёс зүйн тухай хуулийг ажилчдад таниулах сургалтыг онлайн болон цахим хэлбэрээр 3 удаа зохион байгуулсан

-Төвийн ажилчид танхимд-20 хүн

-Сумдын ажилчид онлайн хурал хэлбэрээр-45 хүн

-Пейж дээр хичээлийн презентэйшн байрлуулж унших хэлбэр-68 хүн үзсэн

3.2.3 Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийг ажиллуулах

Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл нь 2018 оны хүүхдийн төлөө үндэсний зөвлөлөөс гаргасан 03 дугаартай тогтоолыг үйл ажиллагааныхаа чиг болгон 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө боловсруулж тогтоолд багтасан чиглэлийн дагуу нийт албан хаагчдаас гэр бүл хүүхдийн судалгаа авч ажиллаа. Нийт 74 албан хаагч байгаагаас 42 хүн гэр хүүхдийн судалгааг бөглөж ирүүлсэн байна. Сэлэнгэ аймгийн цаг уурын байгууллагад 7 албан хаагч гэр бүлээрэй ажиллаж байна.

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан нийт албан хаагчдын хүүхдүүдийн дунд 7-10 насны ангилалд Би том болоод буюу Миний мөрөөдөл сэдвээр гар зургын уралдаан зарлаж 4 байр шалгаруулж урамшууллаа. Шагналыг 2024.06.01-ий өдөр Төв талбай дээр байрласан УЦУОШТөвийн байгууллага сурталчлах үйл ажиллагаан дээр гардуулан өглөө.

Сэлэнгэ аймгийн гэр бүл хүүхэд залуучуудын газраас зохион байгуулсан хүүхдийг орчны эрсдлээс урьдчилан сэргийлэх **“Хамтдаа шалгая, хамгаалъя”** арга хэмжээний хүрээнд Сэлэнгэ аймгийн цаг уурын төвийн идэвхитэй ажиллуулж буй фейсбүүк хуудсуудад “Хамтдаа шалгая, хамгаалъя” арга хэмжээний постер, үнэлгээний аргазүйг байршуулж олон нийтэд сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллаа. Сэлэнгэ аймгийн цаг уурын 2 пэйж, салбар дундын 8 пэйж хуудсууд идэвхитэй ажиллаж байна.

Байгууллагын хөдөлмөр хамгааллын инженер Л.Баярмөнх болон эцэг эхийн зөвлөл хамтран байгууллагын гадаад дотоод орчинд эрсдэл байгаа эсэхийг тодорхойлоход дотоод орчинд мэдээлэл үйлчилгээний өрөөнд уртасгагчинд залгасан залгуурууд хоорондоо орооцолдсон замбраагүй байдалтай, паарны урд хаалтыг онгойлгосон зэрэг бага зэргийн эрсдэл илэрсэн бол гадаад орчинд камер, гэрэлтүүлэгтэй, дээврээс илүү унжсан цахилгааны утас, унах эрсдэлтэй зүйл байхгүй байсан бөгөөд эдгээр илэрсэн бага зэргийн эрсдлүүдийг арилгах талаар байгууллагын удирдлагад танилцуулж ойрын хугацаанд арга хэмжээ авч ажиллахаар ажиллаж байна.

3.2.4 Байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх

Ус цаг уур орчны шинжилгээний газрын хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх зорилтын хүрээнд 2024 оны сургалтын ажлын төлөвлөгөөний дагуу 2 чиглэлээр 15 ажил төлөвлөн ажиллаж байна. Тус төвийн инженер техникийн ажилтнуудын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд тогтмол анхаарч ажилтнуудаа гадаад, дотоод төв, орон нутгаас зохион байгуулсан сургалт семинаруудад бүрэн оролцуулахаар дэмжин ажилладаг. Байгууллагын зүгээс албан хаагчдыг мэргэшүүлэх, мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх арга хэмжээг тогтмол дэмжин ажилладаг бөгөөд ЦУОШГ, бусад байгууллагуудаас зохион байгуулсан урт богино хугацааны мэргэжлийн сургалтуудад нийт 76 албан хаагч хамрагдсан байна. Жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний дагуу 100%-ийн гүйцэтгэлтэй байна.

2024 оны 12-р сарын 1-нээс 11-р сарын 30-нийг хүртэл давхардсан тоогоор хүн 105 өдрийн 250 цагийн сургалтанд хамрагдсан байна.

Мөн сум орон нутаг, төрийн болон төрийн бус байгууллагуудаас зохион байгуулдаг мэдлэг чадвар олгох төрөл бүрийн сургалтуудад албан хаагчдыг идэвхтэй оролцуулж дэмжин ажиллаж байна.

3.2.5 Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах

Байгууллагын албан хаагчдын “Ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа”-г хангах 52 заалт бүхий төлөвлөгөө, “Манлайлал, мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх” 6 бүлэг 43 заалт бүхий хөтөлбөрүүдийн биелэлтийг хангах зорилгоор жил бүр хийх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 100%-ийн биелэлттэй байна.

Газар олголт, Оюуны чадавх боломжоо ашиглан орлого нэмэгдүүлэх тал дээр байгууллагад ирсэн хүсэлт байхгүй болно

3.2.6 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны эрүүл ахуйн журам, зааврыг бүх салбарын ажиллагсдад мөрдүүлэн ажиллах, зааварчилгаа өгч баталгаажуулалт хийх

2024 оны хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн талаар хийх ажлын төлөвлөгөөг гарган ус цаг уур орчны шинжилгээний төвийн даргаар батлуулан төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэж байна. БОШЛабораторид усны

дээж авахад мөс цөмөрхөөс хамгаалж банз болон өөрийгөө уях уяа зэргээр хангаж, зарим станцуудын болон төвийн хуучин камеруудыг засаж хэвийн ажиллагаатай болгосон. БОШЛабораторийн ажилчдад хлад, резинэн бээлий, давхар шүүлтүүртэй маск, усны инженер техникч нарт усны гутал, өвлийн нормын гутал, дулаан хувцас, Цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедицийн бүрэлдэхүүнд дулаан хувцас, малгай, гутал авто машины граш болон өртөөнүүдэд галын хор, авто машинуудын сэлбэг хэрэгсэлд 4,5 сая төгрөг тусгуулж сэлбэг авсан

Цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедицүүдийн бие бүрэлдэхүүнд тоног төхөөрөмж, техникийн аюулгүй ажиллагааны дүрмийг танилцуулж, аянга зайлуулагчтай болгож, алсын зайнаас утасгүй удирдлагаар пуужин харвах болон хээрийн ажиллагааны үед анхаарч ажиллах зүйлийн талаар тодорхой зааварчилгаа, зөвлөмж өгч ажилласны дээр үйл ажиллагаанд гарах тохиолдол бүрт хүн нэг бүрээр гарын үсэг зуруулан аюулгүй ажиллагааны дүрэм сахин ажиллахыг анхааруулж зөвлөмж өгч ажиллав.

Ус судлал аюулгүй ажиллагааны дүрмийг бүх харуулын ажиглагч нарт танилцуулан гарын үсэг зуруулж аюулгүй ажиллагааг хангах талаар зөвлөмж өгөн ажиллалаа.

Өртөө харуулуудад өвлийн улиралд цаг уурын ажиглалт хийхдээ төмөр шатнаас халтирч унахаас сэргийлж барих тулгуур бариул хийлгэх, лабораторийн химийн хортой бодисын хадгалалт, устгалтанд тогтмол хяналт тавьж ажиллаж байна.

Мөн бүх өртөөнд хөдөлмөр хамгаалал галын булан байгуулж галын хороор хангаж аюулгүй ажиллагааны журмыг мөрдүүлэн ажиллаж байна.

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн талаар:

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн журам, холбогдох хууль тогтоомжийг салбарын ажилтнуудад танилцуулж хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зохицуулалт, арга зүйгээр хангаж нийт ажилтан албан хаагчийн аюулгүй байдал, эрүүл ахуй, гамшгаас хамгаалах, эрүүл ахуйн ажиллагааны талаар шинэчилсэн заавар, журмуудыг хэвлэж салбар болгонд тарааж танилцуулж, гарын үсэг зуруулж ажиллав. Үүнд:

Холбоо сүлжээний инженер, синоптик инженерүүдэд:

-Холбоо, цахим тооцоолуурын тоног төхөөрөмж компьютер дээр ажиллах, сүлжээний шугам сүлжилт оруулгын төхөөрөмж дээр ажиллах галын аюулгүй байдлыг хангаж ажиллах зэрэг аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгсөн.

Усны ажиглагч инженер, техникч нарт:

-Ус судлал, усны түвшний хэмжилт хийх, усны өнгөрөлт хэмжих, мөсөн дээр ажиллах, ус мөсөнд унасан хүнийг аврах, гүүр буюу дүүжин гарам дээр ажиллах үеийн аюулгүй ажиллагаа мөн гол мөрний усан дээр ажилладаг ажилчдад мөс цөмрөхөөс хамгаалсан банз, урт уяа зэргээр хангаж тогтмол аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч ажилласан.

Байгаль орчны шинжилгээний лабораторын инженер техникч нарт:

-Байгаль орчны шинжилгээний лабораторид ажиллах, хүчил шүлттэй ажиллах, химийн хортой бодистой ажиллах, галын аюултай ба тэсрэмтгий бодистой ажиллах, лабораторын цахилгаан тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл дээр ажиллах, хийн баллонтой ажиллах, химийн сав суулгатай ажиллах, химийн хортой бодис урвалжийг хадгалах, Лабораторын ажилтныг шинжилгээний ажил хийж байх үедээ анхаарал болгоомжтой ажиллах, хөнгөн шарх авсан тохиолдолд анхны тусламж үзүүлэх мэдлэгтэй байх үүднээс ослын үед анхны тусламж үзүүлэх ерөнхий журмыг уншуулж танилцуулсан.

Цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедицийн бие бүрэлдэхүүнд:

Цаг агаарт зориудаар нөлөөлөх ажиллагааг зохион байгуулахдаа ЦУОШГ, ИНЕГ-ын даргын 2011 оны хамтарсан А/450/167 дугаар тушаалаар батлагдсан “Цаг агаарт зориудаар нөлөөлөх үед агаарын хөлгийн нислэгийн аюулгүй байдлыг хангах” журам, Цагдаагийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2015 оны хамтарсан А/32/231 дугаар тушаалаар батлагдсан “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн үед мөрдөх аюулгүй ажиллагааны журам”, “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн холбогдох заалт болон 2010 оны ЦУОШГазрын даргын 66 дугаар тушаал хүчингүй болж 2017 оны ЦУОШГазрын даргын А/ 38 дугаар тушаалаар шинэчлэгдсэн цаг агаарт зориудаар нөлөөлөх ажлын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөж ажиллаа. Үүнд: Цаг агаарт зориудаар нөлөөлөх аюулгүй ажиллагааны заавар, газрын төхөөрөмж дээр ажиллах үеийн аюулгүй ажиллагаа, пуужин галт хэрэгслийн аюулгүй байдлыг хангах, хадгалах, харвах төхөөрөмж дээр ажиллах, газрын генератор дээр ажиллах үеийн аюулгүй ажиллагаа, явуулын радарын станцын аюулгүй ажиллагаа зэрэг заавруудыг танилцуулж үйл ажиллагаа явуулах бүрт хүн тус бүрээр тогтмол гарын үсэг зуруулж ажиллав.

Уур амьсгалын инженер техникч, ХАА-н инженер техникч, Цаг уурын станц харуулын ажиглагч нарт: Галын аюулгүй байдал, Цахилгааны аюулгүй байдал, Цаг уурын өртөөн дээр ажиллах үеийн аюулгүй ажиллагааны заавар, компьютер, цахим тооцоолуур дээр ажиллах мөн хальтрахаас болгоомжилсон сануулга, Салбар ахалсан инженерүүдээр нь болон өөрийн биеэр шалган туслах ажлын үед газар дээр нь очиж зааварчилгаа өгч, ажиллаж байсан.

3. Бусад ажлын талаар

Бүх станцуудад гал гарч болох шалтгаан нөхцөлүүд, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам, гал гарсан үед авах анхан шатны арга хэмжээ, галын дуудлага өгөх, гал унтраах хэрэгслийг хэрэглэх, ашиглах, хүн эд материал аврах гэх мэт заавар зөвөлгөөг өгч, элс хийх хувин, эмийн сан, галын хор зэргээр хангаж галын булантай болгосон.

-Ажилчдыг хачигны эсрэг вакцинд хамруулсан

-Байгууллагын ойр орчмоор явган хүн явахад хальтархаас сэргийлж цас орсны дараа байнга цасыг цэвэрлэж, байгууллагын өмнөх болон хажуу талын машины замын цасыг цэвэрлэж хальтаргаа гулгаанаас сэргийлж байв.

3.3. БАЙГУУЛЛАГЫН АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ

3.3.1 Байгууллагын архив, бичиг баримтыг холбогдох хууль, тогтоомж, стандарт, заавар журмын дагуу эрхлэн явуулах:

Тайлангийн хугацаанд ЦУОШГазар, аймаг болон холбогдох газруудаас нийт 296 албан бичиг ирсэнээс 91 хариутай бичиг хүлээн авч хяналтанд аван цаг хугацаанд нь хариуг явуулсан байна.

Ард иргэд ажилтан албан хаагчдаас 20 өргөдөл, гомдол хүлээн авч 20 өргөдлийг барагдуулсан ба Удирдлагын үйл ажиллагаанаас үүсч хөтлөгдсөн нийт 212 бичиг баримт, төвийн даргын А тушаал 72, Б тушаал 51, нийт 123 тушаалыг стандартын дагуу баримтжуулан боловсруулан бүрдүүлж ангилан төрөлжүүлж ажилласан.

Төрийн байгууллагын дотоод удирдлагын нэгдсэн систем ERP-ыг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа ашиглаж байна

Архивын талаар хийсэн ажил

Тус төв нь үйл ажиллагаандаа Архив албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар журам, баримт бичгийн стандарт болон холбогдох хууль тогтоол заавар журмыг мөрдлөг болгон, удирдлагын үйл ажиллагааг стандартын дагуу зөв баримтжуулах, баримт бичиг боловсруулах бүрдүүлэх хүлээн авах хянан шийдвэрлэх ангилан төрөлжүүлэх, эмх цэгц бүрдэл хадгалалт ашиглалтыг сайжруулах талаар хяналт тавин ажиллаа.

Байгууллагын архив албан хэрэг хөтлөлт стандартын түвшинд хөтлөгдсөн Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, Байгууллагын үйл ажиллагаанд үүссэн удирдлагын нийтлэг баримт бичиг хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалтыг баримтлан боловсруулан аймгийн Архивын тасгаар хянуулан төвийн даргаар батлуулж мөрдөн ажиллаж байна.

2023 оны байнга хадгалах 16 хадгаламжийн нэгж, 1-70 жил хадгалах 5 хадгаламжийн нэгж, Түр хадгалах 18 хадгаламжийн нэгжид данс бүртгэл үйлдэн байгууллагын архивт шилжүүлэх ажил хийгдсэн. Мөн 2023 оны А, Б тушаалыг скайнар дан цахим файл болгосон.

Архив албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомж арга зүйн бичгүүдийг нийт албан хаагчдаар судлуулж заавар зөвлөмжөөр хангаж Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулахдаа салбар ахалсан инженерүүдээс саналыг аван боловсруулан.

2024 оны 06 дугаар сарын 02-ний өдрийн А/08 тоот тушаалаар баримт бичиг нягтлан шалгах тооллогын комисс байгуулан ажиллаж байна. Баримт нягтлан шалгах комиссын хурлаар дараах зүйлийг шалгаж тогтоов. Үүнд: Данс бүртгэлээр нийт 270 хадгаламжийн нэгж байна. үдэж хавтаслах шаардлагатай 18 хадгаламжийн нэгж, бичвэр тодруулах шаардлагатай 8 хадгаламжийн нэгж байна гэж баримтын тооллогын комисс шалган тогтоон дахин сэлбэн засварласан байна. Мөн Хадгалах хугацаа дууссан түүх эрдэм шинжилгээний болон практик ач холбогдолгүй 1985-2017 оны 68 хадгаламжийн нэгжийг устгахаар ялгасан ба устгах хэргийн актанд орсон тул Баримт нягтлан шалгах комиссоор хэлэлцүүлэн устгахаар тогтоож актыг аймгийн архивын тасагт хүргүүлэн

ажилласан. Сэлэнгэ аймгийн Архивын тасгаас холбогдох шаардлагуудыг хангасан тул ямар нэгэн санал байхгүй болно гэсний дагуу заавар журмын дагуу актлах ажил хийгдсэн байна.

Байгууллагын архивын өрөөнд 7 хоногт 2 удаа баримтын тоос шороог цэвэрлэж сард нэг удаа чийгтэй цэвэрлэгээ хийгдсэн бөгөөд чийг дулаанд тогтмол хяналт тавин ажиллаж байна

Сэлэнгэ аймгийн Төрийн архиваас мэргэжил арга зүйн зөвлөгөө авч улсын архивын урьдчилсан шалгалтанд хамрагдсан байна.

Энэ онд Архивын ерөнхий газраас Цаг уур, орчны шинжилгээний газрын албан хаагчдад болон Захиргаа, аудитын хэлтсээс зохион байгуулах харъяа байгууллагуудын байгууллагын архив хариуцсан албан хаагчдад зориулсан сургалтуудад хамрагдсан байна.

3.4. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ

3.4.1 Албан хаагчдын улирал, хагас жил, бүтэн жилээр үнэлж дүгнэх

Албан хаагчдын болон нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж төвийн даргаар батлуулан хяналт шинжилгээ үнэлгээний багийг томилон улирал бүр хэрэгжилтийг гаргаж албан хаагчдын ажлыг дүгнэж үнэлэлт өгч ажиллалаа.

3.4.2 Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан биелэлтийн тайланд үнэлгээ өгч хүргүүлэх.

2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан аймгийн Засаг дарга, ЦУОШГ-ын дарга нараар батлуулан ажиллаж байна. Байгууллагын хагас жилийн тайланг хуулийн хугацаанд бүрэн тайлагнаж хүргүүлэв.

3.4.3 Бүх салбар нэгжид шалган туслах ажлыг хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэж зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил аргагүйн удирдлагаар ханган ажиллах

Гэнэтийн болон төлөвлөгөөт шалгалтыг давхардсан тоогоор 27 салбарт цахимаар болон биечлэн 91 удаа хийж, ажлын биелэлт 98.9 хувь дүгнэгдэж, өмнөх оноос 0.3 хувиар ахисан байна. Автомат станц, тоног төхөөрөмжийг аянгаас хамгаалах тухай зөвлөмж хүргүүлэв. 100%

3.4.4 Байгууллага салбар нэгжийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх

Тухайн жилд дотоод аудитын шугамаар 5-н ажил зохион байгуулж алдаа дутагдал гаргасан салбар, хувь хүмүүстэй мөн байгууллагын shilendans.gov.mn-ээр хандаж орж сар болгоны санхүүгийн үйл ажиллагааг хянахаас гадна байгууллага дээр гарч буй алдаа дутагдалыг засах талаар мөн ажлын доголдолыг арилгах цаашдаа алдахгүй байх тал дээр анхааруулан хэлж заавар зөвлөж хүргүүлэн ажилласан. Цаашдаа ирэх оныхоо төлөвлөгөөндөө энэ жилийн алдаа дутагдалаасаа суралцаж улам хичээл зүтгэл гарган ажилласан байна.

4.1 ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

4.1.1 Аймгийн уур амьсгалын лавлах шинэчлэх түүвэр судалгаа хийх

2023 оны Аймгийн уур амьсгалын түүврийг 65 үзүүлэлтээр жилийн эмхтгэл хийж дуусгасан.

Аюултай үзэгдлийн түүврийг салбар бүрээр 2024 оныг дуустал үргэлжлүүлэн хийх

Аюултай үзэгдлийн түүврийг салбар бүрээр хийгдэж байгаа.

Сум бүрээр гангийн индекс бодож дууссан, 2024-2025 он зудын эрсдлийн үнэлгээ хийх

2024 оны гангийн индекс бодож дууссан, 2024-2025 он зудын эрсдлийн үнэлгээ хийсэн.

Тоон прогнозын загварын үр дүнг орон нутагтаа турших

Тоон прогнозын загварын үр дүнг орон нутагтаа турших ажил үргэлжилэн хийгдэж байгаа.

ХААЦУ-ын жилийн эмхэтгэл гаргах

Сэлэнгэ аймагт зонхилон ургадаг ургамлаар ургамлын таних гарын авлага, царцааны тархалтын хатаамал хийсэн. 2024 оны ХААЦУ-ын 22 үзүүлэлтээр жилийн эмхтгэл хийж байгаа

4.1.2 Ерөө цаг уурын өртөөний барилга, төвийн өргөтгөлийн байрны дээврийн засвар, конторын гадна фасадын их засварын ажлын ХО-ын санхүүжилтээр хийх.

Ажилчдын ажиллах ая тухтай орчныг бүрдүүлэх зорилгоор БОАЖСайдад удаа дараа уламжлан 2024 оны хөрөнгө оруулалтын зардалд 42,6 сая төгрөгийн санхүүжилтийг шийдүүлж тендерийн хөрөнгө оруулалтын ажлыг аймагт эрхийг нь шилжүүлж тендерийн ажлын хэсэгт оролцон хяналт тавин 2024 -07-16 ны өдөр Есөн Хэлхээ ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж 2024 рны 8-р сарын 08 ны өдрийн 01 тоот актын дагуу хүлээн авч УЦУОШТөвийн даргын 2024-10-30 ны А/71 тоот тушаалаар үндсэн хөрөнгөнд бүртгэсэн болно.

Мөн Ерөө цаг уурын өртөөний барилгын ажил нь он дамнан хийгдэж санхүүжилтийг өглөг авлага үүсгэн авч үлдэж 2024 өны 05-15 ны өдөр засварын ажлыг хүлээн авч ашиглалтанд оруулж. ТӨБЗГазрын 523 тоот тогтоолын дагуу 39.100.000 төгрөгийн өртөгтэйгээр барилга байгууламжийн дансанд бүртгэсэн болно.

Конторын гадна фасадын их засварын ажлын ХО-ын санхүүжилт нь 2024 онд батлагдаагүй болно.

4.1.3 1986-2023 он хүртэлх байгаль орчны төлөв байдлын тоймыг эмхэтгэн хэвлүүлэх

1986-2023 он хүртэлх Сэлэнгэ мөрөн, Орхон гол, Туул голын шинжилгээний судалгаа хийгдэж дууссан.

4.1.5 ЦУ-ын автомат станцуудын мэдээг улсын нэгдсэн сүлжээнд оруулах сүлжээнд оруулах

Сүхбаатар, Баруунхараа, Орхонтуул, Цагааннуур, Бугант, Ерөө станцуудад дата модем суурьлуулж улсын сүлжээнд оруулан мэдээлэл үйлчилгээнд бүрэн ашиглаж байна.Ерөө станцад шинээр AWS310b маркын автомат станц суурьлуулж бүрэн ашиглаж байна.Орхон станцыг шинэчлэх ажил явагдаж байна.Зүүнбүрэн харуулын антенн цахилгааны гэмтлээс үүдэлтэй гэмтэл гарсан тул засварлах ажил хийгдэж байгаа бөгөөд автомат багажийг түр салгасан. 100%

4.1.6 ЦУОШТ-ийн аянга зайлуулагч суурилуулах

_Төвийн тоног төхөөрөмжийг хамгаалахын тулд аянга зайлуулагчийг суурилуулан холбосон 100%

Цаг уур орчны шинжилгээний газарт тавих санал хүсэлт

1.Байгууллагын барилгын гадна талын фассадны засварын ажлыг шийдвэрлэж өгөх

Ус цаг уур орчны шинжилгээний төв